

УЛС ТӨРЧИЙН
СЭТГЭЛ ЗҮРХ БА ХАРИУЦЛААГА



Вильгелм Финк хэвлэлийн газраас хэвлэх эрхийг
авч өгсөн зөвлөх
Др. Клаус Петер-Трайдрт
болон номын редактор
Г.Адьяа
нартаа гүн талархал илэрхийлье.

Impressum

„Die Verantwortung des Politikers“

/Улс төрчийн сэтгэл зүрх ба хариуцлага/

Helmut Shmidth

Published by Friedrich-Ebert-Stiftung, Ulaanbaatar, Mongolia 2013

Contact: Friedrich-Ebert-Stiftung, Ulaanbaatar, Mongolia

Address: Red Cross Building
Sukhbaatar district
Ulaanbaatar-210648
Mongolia P.O. Box-831

Telephone: +976 11 312892

Fax: +976 11 312889

Homepage: www.fes.de

E-mail: oyun@fesmongol.net

Агуулга

1. Орчуулагчийн зурвас	5.
2. Хэлмут Шмидт: Улс төрчийн сэтгэл зүрх ба хариуцлага	7.
3. “Герман Европын цээжинд, Герман Европтой хамт” ХБНГУ-ын канцлер асан Хелмут Шмидтийн ГСДН-ын ээлжит их хурал дээр хэлсэн үг	39.
- Европын нэгдэх шаардлага ба түүхэн эх сурвалж	42.
- Европын Холбоо бидэнд хэрэгтэй.	48.
- Германы бодлого тогтвортой, итгэлтэй байх ёстой.	51.
- ЕХ-ны өнөөгийн байдал эрчимтэй ажиллахыг шаардаж байна.	57.
- Найз нөхөддөө хандаж хэлэх үг	63.
4. Илтгэл	
ГСДН-ын Бундестаг дахь бүлгийн дарга Франк-Вальтер Штайнмайерын ГСДН-ын ээлжит их хурал дээр хэлсэн үг	65.



Орчуулагчийн зурвас

Эрхэм уншигч та бүхэндээ германы ард түмний алдарт хүү Хэлмут Шмидтийн “Улс төрчийн хариуцлага” хэмээх номыг герман хэлнээс орчуулан хүргэж байгаадаа баяртай байна. Хэлмут Шмидт нь 1918 онд Хамбург хотноо их сургуулийн багш Густав Шмидтийн гэр бүлд төрсөн. Тэрбээр германы нэрт социалдмократ бөгөөд 1974-1982 онд германы тавдахь ерөнхий сайдаар сонгогдон ажилласан юм. Өдгөө 95 насандаа эрүүл саруул амьдарч улс үндэстэндээ үг сургаалаа хайрласаар суугаа. Хэлмут Шмидт хэмээх энэ алдарт улс төрчийг хүндэлж биширдэг уншигч, молхи орчуулагч надад түүний алдарт илтгэлүүдийг орчуулах нь нэг талаас баяр бахархал, нөгөө талаас асар том хариуцлага байлаа. Энэ ном хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд: Хэлмут Шмидтийн Христиан Вольфийн цуврал илтгэлийн хүрээнд тавьсан “Улс төрчийн хариуцлага” илтгэл, хоёрдугаарт түүний Германы Социалдемократ Намын 2011 оны 12-р сард хуралдсан ээлжит их хурал дээр тавьсан “Герман Европын цээжинд, Герман Европтой хамт” илтгэл, мөн ГСДН-ын Бундестаг дахь бүлгийн дарга Франк Вальтер Штайнмайерийн ГСДН-ын Европын Холбооны талаар баримтлах бодлогын талаар тавьсан илтгэл. Еврогийн хямралын талаар дэлхий дахин ярьж бичиж байгаа энэ үед “Европын Холбоо чухам ямар учраас хэрэгтэй юм бэ? Герман улс тус холбоонд ямар үүрэг гүйцэтгэж байгаа юм бэ? гэдгийг тус илтгэлүүдэд тодорхой тайлбарласан тул монгол улсынхаа төрийн жолоог атган суугаа улс төрчид, улс төр сонирхогчид та бүхнийхээ мэдлэг ухааралд тустай болов уу? хэмээн үзлээ.

Та бүхний маань бодлого шийдвэр мэргэн байж Монгол Улс
маань мандан бадрах болтугай.

Герман хэлнээс орчуулсан Фридрих-Эбертийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал
Чогдонгийн Оюунгэрэл

Улаанбаатар хот
2013 оны 8-р сарын 23

ХЭЛМУТ ШМИДТ

**УЛС ТӨРЧИЙН
СЭТГЭЛ ЗҮРХ БА ХАРИУЦЛАГА**



Ноён ерөнхийлөгч, хатагтай, ноёд оо,

Юуны өмнө би ноён Гэтьмань, ноён профессор Яанич нарын нэр дээр тус факультетад талархлаа илэрхийлье. Өнөөдөр факультет биш мэргэжлийн салбар гэж нэрлэдэг болсон шүү дээ. Харин та бүхэн миний алдааг шүүмжлэлгүй чимээгүйхэн өнгөрөөчихлөө. Гар өргөөд залруулсан бол би шүүмжлэлийг талархалтайгаар хүлээн авах байлаа.

Христиан Вольфын цуврал илтгэлүүдийн хүрээнд ярих үүргийг надад хүлээлгэсэн тул өөрийнхөө боловсролын нэгэн том дутагдалтай талыг муу нуухаар сайн илчилчихсэн нь дээр гэж бодлоо. Учир нь миний Христиан Вольфын тухай мэдлэг бүдэг бадагхан төсөөллөөс хэтрэхгүй. Лайвниц, Спиноза, Декартес нарын талаархи мэдлэгээс маань ч үүнээсээ төдийлөн дээрдэхгүй. Ямартай ч Вольфын намтрын өчүүхэн хэсэг болох нэгэн харамсалтай явдлын тухай түүх санаанд минь тодхон үлдсэн бөгөөд Халленсерын Евангелын шашны сургаалыг судлагчид улайран гомдол мэдүүлсний улмаас түүнд Прусыг орхиж гарах шийтгэл ногдуулсан юм. Түүнийг оюун ухааныг сурвалж болгож рационализмыг баримтлав гэж эзэн хаанд гомдол мэдүүлсэн тул Пруссын хаан түүнийг дүүжилж ална хэмээн сүрдүүлсэн гэдэг. Энэ талаар бид түрүүн ч сонслоо. Энэ үйл явдлаас хойш даруй мянганы дөрөвний нэгтэй тэнцэх он жилүүд улиран одсон ч өнөөдөр, миний амьд сэрүүн байхад шашин ба төр хоорондын түүнээс ч илүү аймшигтай мөргөлдөөнийг үзлээ. Тэр нэгэн цаг үед Плоетцензэд энэ үйл явдал тохиосон бол тэднийг үнэхээр дүүжлэх байсан биз. Бид мөн тун

саяхан Галилейг дэмий хараан зүхэж байжээ гэдгийг Гэгээн сандал од олон зууны дараа батлахыг харлаа. Өнөөдөр бид Дундад дорнодод шашны болон улс төрийн хүчнүүд хоорондоо хүмүүсийн сэтгэл оюуныг эзэмдэхийн төлөө өдөр бүр алалдан тэмцэлдэж хүн бүрт заяасан эрүүл саруул оюун ухаан тэрэгний дугуйн дор тахлагдан буйг харцгааж байна. Шашинд хэт автагдаж дотоод ухамсартаа бурхандаа үнэнчээр зүтгэж байна гэдэг итгэл үнэмшилтэйгээр алан хядагчид 2001 онд Нью Йорк хотноо гурван мянган хүний амь насыг өөрсдийнхөө амь настай хамт егүүтгэсэн билээ. Бурхныг шүтсэнгүй гэж Сократыг цаазаар хороосноос хойш хоёр мянга таван зуун жил өнгөрчихөөд байхад шүү дээ.

I.

Энэ бүхний дараа надад хүмүүс байгаа цагт шашин, эрүүл саруул ухаан, улс төр хоорондын он удаан жилийн зөрчил дуусахгүй үргэлжилсээр л байх юм байна, энэ нь (*conditio humana*) хүн гэдэг бодьгалын унаган төрхийн нэгэн шинж юм гэж бодогдох боллоо. Саяхан Франц, Голландад Европын Холбооны нэгдсэн үндсэн хуулийн төслийг зөвшөөрч буй эсэх талаар бүх ард түмний санал асуулга явуулахад зарим хүмүүс бурхныг дурьдалгүй орхилоо гэдэг онцгой шалтгаанаар уг төслийг батлахаас татгалзлаа. Тэдгээр нь ихэвчлэн улс төрчид төдийгүй сүм хийдүүдийн хурлын таслах эрх бүхий гишүүд байсан бөгөөд тэд л өөрсдөө өмнө нь төслийг хэлэлцэх үед олонхоороо бурхныг дурьдахаас татгалзсан юм. Германы үндсэн хуульд бурхныг гагцхүү үндсэн хуулийн оршил хэсэгт л дурдсан байдаг агаад “Дотоод ухамсартаа бурхны өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан”

гэж эхлээд шууд үндсэн хуулийн текст эхэлдэг. Дараа нь албан тангаргийн текстийн 56-р зүйлийн төгсгөлд “ Бурхан надад ингэж тусалсан юм.” гэж төгсдөг. Дараа нь үргэлжлэл болгон үндсэн хуульд “Тангаргийг бурхны нэрийн өмнөөс өргөхгүй байж болно.” гэж заасан байдаг. 1948/49 оны үед улс төрчдийн олонх энэ текстийг томьёолсон юм. Эрх зүйт төрт ардчилсан нийгмийн байгуулалд үндсэн хуулийн үзэл санаанд улс төрчид, тэдний эрүүл саруул ухаан шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг, харин тэдний ямар шашин шүтдэг болон номын багш нь хэн бэ? гэдэг төдийлөн чухал үүрэг гүйцэтгэдэггүй.

Энд би өөрийн амьдралын туршлагаас жишээ болгон үг хавчуулаад авъя. Би Нацигийн үед (үндэсний социалистууд засгийн эрхэнд байхад) насанд хүрсэн. 1933 оны эхээр би дөнгөж 14 нас хүрч байлаа. 8 жил цэргийн алба хааж байхдаа тухайн үеийн хүнд хямралыг гэтлэн давахад Христосын шашны сүм хийдүүд гол үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэдэг байлаа. Хямрал болно гэдэг нь тодорхой байсан шүү дээ. Харин 1945 оны дараа шинэ зан суртахууныг бүрдүүлэхэд сүм хийдүүд тулгуур нь болж чадахгүй гэдэг нь тодорхой болсон юм. Тэд мөн ардчилал, эрх зүйт төрийг шинээр байгуулж чадахгүй гэдэг нь тодорхой болсон юм. Миний харьяалагддаг байсан сүм Ромын Паулын захидлыг номлохоос хэтрэхгүй. Уг захидал дээдэст захирагдахыг л номлоно. Сүм хийдүүд биш харин Ваймарын Бүгд Найрамдах Улсын үеийн Аденаур, Шумахер, Хойс нарын зарим туршлагатай улс төрчид шинэ үеийг эхлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Баруун Германыг ардчиллын замаар замнахад хуучин Ваймарын Бүгд Найрамдах улсын улс төрчид төдийлөн чухал үүрэг

гүйцэтгээгүй. Харин Людвиг Эрхардс болон Америкийн Маршалын туслалцааны эдийн засгийн гайхалтай амжилт илүү чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тэд шинэ цагийн эхэнд Германчуудыг эрх чөлөө, ардчилал, эрх зүйт төрд элэгтэй болгоход нөлөөлсөн. Би энэ бодит үнэнийг хэлэхээс ичих хэрэггүй гэж боддог. Аль Карл Марксын үеэс л эдийн засгийн оршихуй улс төрийн ухамсрыг тодорхойлдог гэдгийг бид мэддэг болсон. Мэдээж энэ бол үнэний нэгээхэн хэсэг, гэхдээ үүний дотроос нэгэн хөдөлшгүй үнэн бол: Засгийн эрхийг баригчид эдийн засаг, хөдөлмөрийн журмыг нийтэд хүлээн зөвшөөрөгдөх зохистой хэмжээнд тогтоож чадахгүй бол ардчилал аюулд учирдаг. Бүх ардчилалд аюул учирдаг.

Миний бие засгийн газрыг тэргүүлж байсан үеэсээ хойш зууны дөрөвний нэгтэй тэнцэх хугацаанд их зүйлийг сурч мэдлээ. Их ч юм уншлаа. Цаг завтай ч болсон юм. Би бусад шашнуудын тухай, мөн өмнө нь надад төдийлөн танил бус байсан философийн талаар ч бага сага уншлаа. Ийнхүү мэдлэгээ нэмсний хүчинд бусад шашны талаар баримталдаг байр суурь минь илүү уян хатан болсон юм. Нөгөө талаар миний Христосын шашны талаар баримталдаг байр суурь минь өөрчлөгдөж илүү зай барих болсон юм. Тэгсэн хэдий ч би сүм хийдүүд олон хүнийг зан суртахууны доройтлоос аварч тэдэнд түшиг тулгуур нь болдог учраас өөрийгөө Христосын шашинтан гэж нэрлэсээр сүмдээ тогтмол очиж мөргөлөө үйлдсээр байгаа.

Христосын шашны бусад шашныг хүлээн зөвшөөрдөггүй байдал нь надад саад болдог. Энэ дутагдал зөвхөн Христосын шашинд бус бусад шашинд ч байдаг. Чамд тэгэх эрх байхгүй,

харин би бол миний итгэл үнэмшил, миний зорилтууд бурхны таалалд нийцнэ гэдэгт итгэлтэй байна гэх маягаар бусдад ханддаг. Жорж Буш шашны итгэл үнэмшлээрээ асуудалд ханддаг хүний хувьд мусульманы шашинт дарангуйлагч Саддам Хусейныг хүчээр зайлуулахдаа бурхны нэрийн өмнөөс түүнийгээ хийж байна гэдэг итгэлтэйгээр хандсан байх. Эсвэл Кардинал Ратцингер (Пап лам болохоосоо өмнө) “ Улс орнуудын туршлага дээр үндэслэн хүн төрөлхтнөөс гэв гэнэтхэн Христосын шашны зан суртахууны сүр хүчийг нь булаан авах юм бол хүн төрөлхтний оршихуйд хамгийн аймшигтай аюул нүүрлэнэ гэдгийг баттай хэлэх байна.” гэж бичсэн байдаг. Тэрээр улс орнуудын туршлага дээр үндэслэн баттай хэлж чадна гэж бичиж байсан юм шүү. Энэ мэтчилэн зөвхөн өөртөө зөв шашны тодорхой нотолгоонууд нь олон мянган жилийн туршид асар их гай зовлон дагуулсан билээ.

Өнөөдөр 21-р зууны эхэнд дэлхий дахинд шашны үүсэлтэй, шашнаар гул барьсан соёл иргэншлүүдийн хоорондын мөргөлдөөн бодитоор нүүрлэж байгаад миний сэтгэл маш ихээр зовниж байна. Дэлхийн зарим өнцөг буланд ядуу зүдүү байдалдаа дургүйцсэн эгдүүцэл, бусдын хангалуун чинээлэг амьдралд атаархсан атаархал нь шашны эзэрхэг үзэл болон шашны сургаалыг ашиглан журам дэглэмийг эвдэх ноёрхог үзэлтэй холилдон байна. Тэнд эрүүл ухаанаар эргэцүүлэн тунгаасан ухаалаг байдлын аядуу дуу хоолойг сонсохыг ч хүсэхгүй байна. Бүхэлдээ сэтгэлийн хөөрөлд автсан хүмүүст ухаалаг байхыг уриалаад ч нэмэргүй.

Үүнтэй нэгэн адил Хинди шашинтан, Исламын шашинтан хоорондын харилцаа, исламын шашинтан, үнэн алдартны

шашинтны харьцаа, Христосын шашинтан исламын шашинтнуудын харилцаанд ч бэрхшээл байна. Христосын шашинтнуудын Еврейчүүдийг аймшигтайгаар үзэн ядах явдал Гитлерээр төгсгөл болсон гэдэгт бүрэн итгэлтэй байж болохгүй байна. Юунд ч бүрэн итгэлтэй байж болохгүй цаг үе иржээ. Миний бодлоор хамгийн эмгэнэлтэй жүжиг бол дэлхий дахинаа Абрахамын гурван шашны сүсэгтнүүд бусад шашны талаар, зарим нэг магтан сайшаамаар онцгой тохиолдлуудыг эс тооцвол бараг юу ч мэддэггүй явдал юм. Тэд өөрсдийн шашнуудын нэгдмэл гарал үүсэл, бусад олон ижил төстэй талуудын талаар юу ч мэддэггүй. Тэдэнд Абрахамын шашнуудын үндсэн судруудын ижил төстэй зүйлүүдийн талаар ямар ч ойлголт байхгүй. Тора, Шинэ гэрээс, кураан судар. Харин бүх зүйл дээр раввинчууд, католик шашны лам нар, пасторууд, хамба лам нар, муллахууд, Шийтийн шашны тэргүүн, шийтүүдийн мусульман шашинтнуудын тэргүүнүүд өөрсдөө мэддэг мөртлөө бидэн шиг юу ч мэдэхгүй энгийн сүсэгтнүүдэд энэхүү мэдлэгээ түгээхгүй дотроо хадгалсаар иржээ. Харин ч бүр эсрэгээрээ тэд бидэнд бусад шашныг таньж мэдэлгүйгээр тэдгээрээс татгалзах, тэр ч байтугай муугаар бодохыг сургасаар ирсэн.

Шашнуудын хооронд энхийг хүсэгч хүн бүр бусад шашинд уян хатан, хүндэтгэлтэй хандахыг номлох ёстой гэж би боддог. Бусад шашинд хүндэтгэлтэй хандахын тулд тэдний тухай наад захын мэдлэгтэй байх ёстой. Миний хувьд Абрахамын гурван шашин төдийгүй Хинди шашин, буддизм, Шинтоизмын шашнуудад ч уян хатан, хүндэтгэлтэй хандах шалтгаанууд байдаг гэдэгт итгэлтэй байна.

Гэвч би хоёр мянга таван жилийн өмнө хүн төрөлхтний суут хоёр сэтгэгчдэд зорилгодоо хүрэхийн тулд, нэгдүгээрт бөөрөнхий үзлийг номлодог, хоёрдугаарт тэдний ажилд хэлэх ярихын төдийд үүрэг гүйцэтгэж байсан болохоор шашин шаардлагагүй байжээ гэдгийг ойлгосон. Энэ бүхэн бидэнд танил болсны дараа Сократ философио, Күнз ёс зүйгээ гагцхүү оюун ухаанаа дайчлан байж боловсруулсан гэдгийг бид мэддэг болсон. Тэдний хэн нь ч шашныг үндэс болголгүйгээр сургаалаа туурвисан. Гэсэн хэдий ч тэд өнөөдрийг хүртэл сая сая хүмүүсийн гэрэлт цамхаг болсоор байна. Сократ байгаагүй бол Платон, Аристотель байхгүй, магадгүй Христиан Волф, Имануэл Кант, Карл Поппер нар төрөхгүй байсан биз. Күнз, Күнзийн сургаалгүйгээр дэлхийн хамгийн эртний, хамгийн удаан амьдрах чадвартай хятадын соёл, Дундад эзэнт гүрнийг төсөөлөхөд хэцүү.

Нэгдүгээр Фридрих Вильгельм шашны нэрийг барин Христиан Вольфыг заналхийлсэн нь надад нэгэн зүйлийг ойлгуулсан юм. Гайхалтай мэдлэг чадвар, гайхалтай шинжлэх ухааны бүтээлүүд болон ёс зүй, улс төрийн сургаалуудыг туурвигчид нь ямар нэгэн бурхан, эсхүл бурхад, зөнч мэргэд, бурхны ном, аль нэгэн шашинд захирагдалгүйгээр зөвхөн өөрийн оюун ухааныг дайчилсан үед төрдөг юм байна гэдгийг ойлгосон. Зөвхөн оюун ухаанаа дайчилсан нөхцөлд гайхалтай нээлт, бүтээл төрдөг бололтой.

Энэ нь нийгэм эдийн засгийн болон улс төрийн бүтээл туурвилд ч нэгэн адил хамаатай. Өнөөдөр та бүхний олонтаа ярьсан Европ - Хойд Америкийн соён гэгээрлийн үед, олон зуун жилийн турш хичээл зүтгэл, тэмцлийн үр дүнд дэлхий

ертөнцийн бидний оршин буй хэсгийг “цоолж” дээрх нотолгоог хүлээн зөвшөөрүүлсэн юм. “Цоолох” гэдэг үгийг шинжлэх ухаан, технологитой холбон хэрэглэж байгаа гэдгээ тодруулж хэлье. Харин улс төрд харамсалтай нь цоолох гэдэг үгийг зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хэрэглэх боломжтой.

Жишээ нь: Хоёрдугаар Вильгельм өөрийгөө бурхны ивээлийг хүртэгсдийн эзэн хаан хэмээн өргөмжилсөн үү эсхүл өдгөө Европын улс төрчид Христосын шашны үнэлэмж дээр суурилан үйл ажиллагаагаа явуулдаг уу?: Ямартай ч тэд өөрсдийгөө шашин шүтлэгийн хувьд Христүүд буюу Христосын шашинтнууд гэж ойлгодог. Зарим нь Христосын шашны өмнө хариуцлага хүлээдэг гэж тодорхой бөгөөд ойлгомжтойгоор мэдэрдэг, гэтэл зарим нь энэ хариуцлагыг Германы жирийн иргэдийн нэгэн адил тун тодорхой бус байдлаар мэдэрдэг. Олон Германчууд Христосын шашнаас хөндийрч сүм хийдээ орхисон. Зарим нь бүр бурхнаас хөндийрсөн.

II.

Гэсэн хэдий ч өдгөө амьдарч буй бүх германчуудын хувьд нэгэн чухал, хамтын итгэл үнэмшилтэй байдаг. Би хүний заяамал эрхүүд, эрх зүйт төрийн зарчмууд бол бидний хамтын итгэл үнэмшил гэж ойлгодог. Мөн ардчиллын зарчмууд, нийгмийн баримжаат төрийн зарчмууд бидний нэгдсэн үнэлэмж гэж би боддог. Эдгээр дотоод ухамсрын холбоо хувь хүмүүсийн шашин шүтдэг, эс шүтдэгээс, мөн эдгээр зарчмууд Христосын шашны номлолд байдаггүй гэдгээс үл хамаардаг гэдэг нь тодорхой.

Зөвхөн Христосын шашин бус дэлхийн бусад шашнууд тэдний үндсэн судруудад сүсэгтнүүддээ шаардлага, үүргүүдийг ноогдуулдаг ч хувь бүрийн эрхийн асуудал бараг байдаггүй. Харин манай улсын үндсэн хуулийн эхний хорин бүлэг бараг бүхэлдээ зөвхөн иргэн бүрийн үндсэн хуулиар баталгаажуулсан эрхүүдийг тунхагласан хэрнээ иргэдийн хүлээх хариуцлага, тэдний үүргийн талаар бараг юу ч бичигдээгүй байдаг. Энэхүү үндсэн эрхийн каталог нь Нацист дэглэмийн үед хувь хүн бүрийн эрх, эрх чөлөөг ноцтой хязгаарласны эсрэг үзүүлсэн эрүүл саруул хариу үйлдэл байсан юм. Энэхүү үндсэн эрхүүдийн каталог нь Христосын болон бусад шашнуудын үнэлэмж дээр суурилагагүй бөгөөд гагцхүү манай үндсэн хуульд тодорхой бөгөөд ойлгомжтой илэрхийлсэн хүн бүр халдашгүй дархан байх ёстой гэдэг үнэт зүйл дээр суурилсан.

Үүнтэй нэгэн адил үндсэн хуулийн нэгдүгээр бүлэгт хууль тогтоогчид, гүйцэтгэх засаглал, шүүхийг заавал хангагдах үндсэн эрхүүдтэй холбож өгсөн бөгөөд ингэснээр бүх улс төрчдийг, хууль тогтоогчид, засгийн эрхийг хэмжээний эрх баригчид, захиргааны албан тушаалтнууд уу? эсхүл холбоонд (үндэсний хэмжээнд), холбооны улсуудад, орон нутагт ажиллаж байна уу? гэдгээс нь үл хамааран заавал хангагдах эрхүүдтэй тодорхой хэлбэл үндсэн эрхүүдтэй холбож өгсөн байдаг. Гэхдээ үндсэн хууль улс төрчдөд үйл ажиллагаа явуулах өргөн орон зайг олгодог. Мэдээж улс төрчдөд сайн, амжилттай мөн байдаг л зүйл хойно бүтэлгүй бодлого явуулах боломжийг ч үндсэн хууль олгодог. Амжилтгүй бодлого явуулахыг ч үндсэн хууль зөвшөөрдөг. Нэгэнт бодит байдал ийм хойно бидэнд нэгдүгээрт засгийн

эрхийг баригчид үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээдэг, хоёрдугаарт тэднийг үндсэн хуулийн цэцээс хянадаг байх хэрэгтэй төдийгүй харин гуравдугаарт сонгосон иргэд, олон нийтийн санаа бодол улс төрд хяналт тавьдаг байх нь юу юунаас чухал.

Мэдээж улс төрчид хүн л юм болохоор эндүүрдэг, алдаа хийдэг. Тэд жирийн иргэдийн нэгэн адил өөрийн гэсэн сул талтай байдаг. Олон нийтийн санаа бодол ч буруу ташаа байх нь бий. Зарим үед улс төрчдөд өөрийн зөн мэдрэмж, оюун ухаандаа найдан нэн даруй шийдвэр гаргах шаардлага тулгардаг. Ихэнхдээ тэд хангалттай цаг хугацаатай байж олон талаас санал, зөвлөгөө авах боломжтой байдаг. Хэрэглэж болох олон хувилбарууд, урьдчилан харах боломжтой үр дагавруудыг сайтар эргэцүүлэн цэгнэхэд цаг хугацаа хэрэгтэй. Улс төрчид аливаа нэг онол, үзэл санааг хэт ягштал баримтлах тусмаа эсхүл эсрэгээрээ тодорхой тохиолдолд бүх танигдсан хүчин зүйлс, шийдвэрээс гарах үр дагавруудыг хэдийчинээ бага дүгнэж цэгнэх тусмаа төдийчинээ эндүүрэх, алдаа гаргах, бүтэлгүйтэх аюул нэмэгддэг. Нэн ялангуяа өөрийн зөн мэдрэмж, оюун ухаанд найдан түргэн шийдвэр гаргах үед дээрх эрсдэл мөн л маш өндөр байдаг. Ямар ч тохиолдолд улс төрч гаргасан шийдвэрийнхээ өмнө хариуцлага хүлээдэг. Гаргасан шийдвэр, шийдвэрээс урган гарах үр дагаврын өмнө улс төрч хариуцлагаа хүлээдэг. Уг хариуцлага зарим үед амаргүй, сэтгэл зовоосон байх нь бий.

Би та бүхэнд өөрийн улс төрийн амьдралын туршлагаас зургаан ноцтой жишээн дээр улс төрчид улс төр, эрх зүйн эсвэл зан суртахууны зөрчилдөөн үүсэх үед хүний халдашгүй

дархан байдал, үндсэн хууль, шашин шүтлэг, философи, аливаа нэг онол ямар ч тус болох боломжгүй нөхцөлд хэрхэн шийдвэр гаргадаг бэ? гэдгийг тайлбарлахыг оролдъё. Тэгэхээр та бүхэн минь, ноёд, хатагтай нараа, нэлээд урт илтгэл сонсох хэрэгтэй болох нь дээ. Миний урт илтгэлийг сонссоны дараагаар та бүхэн ерөнхийдөө мэддэг зүйлийг маань л ярилаа гэж бодох болно.

1.

Бундестаг дээр өрнөсөн бусдын амь насыг бүрэлгэсэн этгээдийн хэрэг хөөн хэлэлцэх хугацааг заах эсэх тухай маргаан олон жилийн туршид миний сэтгэлийг ихээр зовоож билээ. Тэр маргааныг хүртэл хорин жилийн дараа хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болдог байсан юм. 1950-иад оны эцсээр үндэсний социалист дэглэмийн үед болсон хүн амины олон хэрэг, хэрэгтнүүд хорин жилийн хугацаа дууссаны дараа олонд танил болж хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул ял завшихад хүрвэл яах бэ? гэдэг асуудал олон хүний санааг зовоож байсан юм. 1960 оноос хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөх, хуулийн хугацааг сунгах тухай олон төсөл боловсруулагдлаа. 1965 ба 1969 онд тус тус мэтгэлцээн өрнөж 1979 онд тун нухацтай авч үзэж үндсэн хуулийн эрх зүйн хувьд бүх боломжоо шавхан мэтгэлцсэн ч парламент тэр хугацаанд алгуурхнаар, алхам алхмаар шийдвэрт ойртсоор байсан юм. Эцэстээ 1979 онд хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тухай заалтыг бүрмөсөн хасахад тэр үеийн гурван фракцын гишүүдээс, манай намын нөхдийн зарим нь эсрэг, зарим нь эсрэг санал өгсөн юм.

Би өөрөө хөөн хэлэлцэх хугацааг үгүй болгохын төлөө саналаа өгсөн бөгөөд Бундестагын гишүүд шийдвэр гаргахдаа зөвхөн өөрийн сэтгэл зүрхээр асуудалд хандах хэрэгтэй, энэ асуудал дээр бүлгийн сахилга батыг баримтлахыг шаардаж болохгүй гэдэг байр суурийг баримталж байсан юм. Зөвшөөрч байна, зөвшөөрөхгүй гэдэг саналын алиныг ч нь өгсөн гишүүд эцэстээ бүгдээрээ өөрийн зөв гэдэгт эргэлзэж байсан ч харин “ Үндсэн хууль тэдэнд за, үгүй хоёрын алиныг нь ч хэлэх эрхийг олгож байгаа” гэдгийг мэдэж байсан юм. Мөн тэд шашин, тэдний шүтдэг шашин ч тэдэнд за, үгүй хоёрын алиныг нь ч зөвшөөрч байгаа гэдгийг мэдэж байсан юм.

2.

Би одоо 1960-аад оны үед Их Эвслийн засгийн газрыг ганхуулж байсан нэгэн асуудлыг жишээ болгоё. Холбооны засгийн газар атомын зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх гэрээнд элсэн орох уу? үгүй юу гэдэг асуудал. Нэн ялангуяа АНУ манай улсыг уг гэрээнд элсэн орохыг, улмаар атомын зэвсэглэлээс татгалзахыг шаардаж байлаа. Түүнээс хэдэн жилийн өмнө АНУ биднээс атомын зэвсэгтэй гүрнүүдийн эгнээнд элсэн орохыг ятгаж байснаа эсрэгээрээ бодлоо өөрчлөөд татгалзахыг шаардах болсон юм. Та бүхэн Multilateral Force гэдэг үгийг санаж байгаа байх. ХБНГУ яаж ч шийдлээ гэсэн олон тооны атомын зэвсэг, нэн ялангуяа Америкийн атомын зэвсэг баруун германы нутаг дэвсгэр дээр, зөвлөлтийн атомын зэвсэг зүүн германы нутаг дэвсгэр дээр үлдэхээр байлаа.

Олон хүмүүс цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх гэрээнд

элсэхийг, цаашилбал Германыг атомын зэвсэглэлээс татгалзахыг зан суртахууны үүднээс дэмжиж байлаа. Зарим нь түүнийг номхон далайн онцлог ашиг сонирхлын үүднээс дэмжиж байлаа. Зарим нь (тэдний дунд би ч байсан юм) уг гэрээг тунгаан бодсоны эцэст бидний зорилгод нийцэж байна гэдэг талаас нь хүлээн зөвшөөрч байлаа. Эсэргүүцэгчдийн шийдвэрт ч мөн зан суртахууны болон ухаалгаар дүгнэж цэгнэн гаргасан үндэслэлүүд байлаа. Герман улс зөвлөлтийн талаас атомын зэвсгийн сүрдүүлгэд өртөөд байсан үе болохоор гэрээнд элсэн орохыг эсэргүүцэх нь мэдээж хэрэг гэж үзэж байсан юм. Ингэснээрээ тэд Герман улс ч мөн атомын зэвсэгтэй болох боломжийг нээлттэй байлгахыг хүсч байлаа.

Эсрэг байр суурийг баримталж байсан хоёр талд үндсэн хууль, библи аль нь ч ямарваа нэг чиг баримжаа өгөөгүй юм. Элсэн орох, элсэн орохоос татгалзах, ингэснээрээ цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхээс татгалзахгүй байх аль аль нь нээлттэй байлаа. Эцэстээ Их Эвслийн засгийн газар шийдвэрийг гаргалгүй хуулийн хугацаагаа дуусгаж дараагийн засгийн газар нийгмийн либерал эвсэл гэрээнд элсэн орох шийдвэрийг гаргаж уг шийдвэрийг Бундестаг олонхоороо баталсан билээ.

3.

Миний гуравдахь жишээ бол НАТО-гийн хос шийдвэр гэж нэрлэгдсэн үйл явдал юм. 1970-аад оны дунд үеэс Дундад Европ, Германыг заналхийлсэн зөвлөлтийн атомын зэвсэглэл миний санааг улам ихээр зовоож байлаа. Тэдгээр

зэвсэглэлийн дотор нисэх онгоц, нэн ялангуяа СС 20 гэдэг нэртэй пуужингууд, хоёулаа дундын зайн тусгалтай тул туйлын ихээр миний санааг зовоож байлаа. Тэдний тусгал Атлантын далайг давахгүй тул Америкт заналхийлэхгүй, харин нэн түрүүнд Германы байнуудыг онилсон байлаа. Тухайн үеийн Америкийн ерөнхийлөгч Жимми Картер Америк зөвлөлтийн дундын зайн тусгалтай пуужингийн цохилтонд алсын зайн тусгалтай пуужингуудаар хариу цохилт өгч чадах болохоор Америкийн чадварт найдаж болно, бүү санаа зов гээд байсан юм. Энэ чадвар зөвлөлтийн удирдлагыг айлгахад хангалттай гэдэг байлаа. Гэхдээ миний хувьд зөвхөн Германыг онилсон атомын пуужингуудаар дамжуулан зөвлөлтийн талаас ирэх олон талт дарамт шахалт ирээдүйд ч мөн Америкийн хүсэл сонирхлын байршил хэвээр байх уу? бидний төлөө атомын дайны үхлийн аюулд ороход бэлэн гэж үү? гэдэг бодол миний толгойн өвчин болж байлаа. Түүнээс гадна ийм нөхцөлд германы олон нийтийн санаа бодол, тухай үеийн засгийн газар зөвлөлтийн дарамтыг удаан хугацаанд тэсэж чадах уу? гэдэгт би эргэлзэж байлаа. Ерөнхийлөгч Жимми Картер бодлоо өөрчлөлгүй үлдсэн болохоор эцэстээ би цөөн тооны дипломатууд, цэргийнхний хүрээнд түгшүүрийн харангаа дэлдсэн юм. Үүний үр дүнд 1979 онд Карибын Гуаделоуп арал дээр миний франц найзын шийдвэрлэх туслалцаатайгаар англи найзтайгаа дөрвүүлээ хамтран хожмоо хос шийдвэр гэж нэрлэгдсэн тэрхүү баримт бичгийг үзэглэсэн юм. Тэр бичгийг сүүлд нь НАТО-гийн зөвлөл өөрийн болгосон. Тухайн үед барууныхан нэг талаас зөвлөлтөд нэгдүгээрт Москвад дундын зайн тусгалын бүх зэвсэглэлийг устгах тухай хэлэлцээр хийхийг санал болгож хоёрдугаарт хэлэлцээр эхэлснээс хойш дөрвөн жилийн

хугацаанд тодорхой үр дүн гарахгүй бол Америкийн дундын зайн тусгалын атомын зэвсгүүдийг зөвлөлтийг онилон Европ тивд суурилуулна гэдгээ мэдэгдсэн юм. Холбооны канцлер Коль миний санааг тууштай дэмжсэний хүчинд хожим социал демократ нам бодлоо өөрчилсөн, эсэргүүцлийн асар том жагсаалууд хийгдэж байсан ч зөвхөн түүний дэмжлэгийн ачаар хос шийдвэрийн хэрэгжүүлэлтийн хоёрдугаар шатанд тавьсан зорилгодоо хүрч чадсан билээ. 1987 онд 1945 оноос хойш анх удаагаа Баруун, Зүүний хооронд зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох тухай анхны гэрээнд гарын үсэг зурж дараа нь Европ тивийн хоёр тал хоёулаа дундын зайны атомын зэвсгүүдээ устгасан юм.

1980-аад оны эхээр гарсан нэгэн шийдвэр манай ард түмний дунд, манай намын хэсэг нөхдийн дургүйцлийг хүргэсний улмаас буй болсон айдас сэтгэлд минь хоногшин үлдэж. Олон нийтийн дунд айдсаа хүлээн зөвшөөрөх нь өдгөө цагт зарим улс төрчдийн хувьд моод болж. Зарим нь эрүүл саруул ухаанаараа, зарим нь Христосын номлолоос ишлэл татан эсэргүүцэж байлаа. Тухайн үед эрүүл бус хөдөлгөөн өрнөж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд элдэв мэдээлэл цацаж дайран дээр давс нэмж байлаа. Хэрэв та бүхэн хүсвэл: Ардчилсан нийгэмд зан суртахууны аргуудыг хууран мэхлэлтээр хүч нэмэгдүүлсэн сэтгэлийн хөөрөл нь эрүүл саруул ухааныг умартуулахад хүргэдгийн нэгэн сургамж нь энэ болсон юм. Хэрэв тухайн үеийн сэтгэл хөдлөлөөр асуудлыг шийдсэн бол, Брежневийг залгамжлагчид Герман улсыг онилсон атомын зэвсгийн заналхийллээ нэмэгдүүлсэн бол 1980-аад оны дэлхийн бодлого Германы хувьд тун таагүй байдлаар эргэж болох байлаа.

4.

Миний дээр дурдсан улс төрийн шийдвэрүүд гурвуулаа цаг хугацааны шахалтад оролгүйгээр дүгнэж цэгнэн гаргасан шийдвэрийн жишээ байлаа. Эдгээр шийдвэрүүд өргөн хүрээнд хэлэлцэн дүгнэж цэгнэн байж гаргасан, дараа нь амьдрал дээр хэрэгжсэн шийдвэрүүд байлаа. Одоо би та бүхэнд цаг хугацааны хувьд асар богино хугацаанд гарсан шийдвэрүүдээсээ гурван жишээг танилцуулъя.

Нэг тохиолдол намайг тун хүнд байдалд оруулсан юм. 1962 оны хавар эрт цагсан. Би Хамбург хотын цагдаагийн даргын албыг аваад хэдхэн долоо хонож байтал манай хот аймшигтай далайн шуурганд өртсөн юм. Хойд Германыг бүхэлд нь хамарч билээ. Эхний шөнө олон хүний амь эрсэдсэн юм. Маш олон хүн эрсэдсэн. Дахиад олон мянган хүний амийг аван одож магадгүй гэдэгт бэлэн байх ёстой байлаа. Иймээс цаг алдалгүйгээр үтэр түргэн олон улсын аврах багийг дуудах шаардлагатай байлаа. Ингэхдээ бид олон хуулийг зөрчсөн юм. Үндсэн хуулийг ч зөрчсөн. Би өнөө та бүхэнд үнэнээ хэлэхэд тухайн үедээ хууль зөрчиж байгаа эсэхээ бид бодоо ч үгүй, тэгэх сөхөө ч байгаагүй юм. Юу юунаас өмнө би хүмүүсийн амь насыг зайлшгүй аюулаас хамгаалах зан суртахууны үүрэгтээ захирагдаж байлаа. Эцэстээ бид 300 хүний амь насны хохиролтойгоор энэ гамшгийг давж гарсан юм. Түүнээс гадна биднийг хууль зөрчлөө гэж аль ч талаас гомдол гаргалгүй өнгөрсөн юм. Германы хувьд гайхамшиг биш гэж үү?

5.

1989 онд Холбооны канцлер Хэлмут Колийн явуулсан үйл ажиллагаа эн тэнцвэргүй нөхцөлд холыг харсан арга хэмжээнүүд байлаа. Тэр үед би түүнийг зөвхөн холоос ажиглан харж байлаа. Дундад Европын зүүн тал бүхэлдээ буцалж байлаа. Польшид, Унгарт, Чехословакт, хуучин Ардчилсан Герман улсад эрх чөлөөний хөдөлгөөнүүд хүчээ авч хүмүүс бөөнөөрөө гудамжинд гарч жагсаалд нэгдэж байлаа. Ийм нөхцөл байдалд тохирсон хөтөлбөр, онол, хууль, мөн барууны эзэмшлийн гүрнүүдтэй хийсэн хэлэлцээр аль аль нь байгаагүй юм. Хүчирхэг Зөвлөлт Холбоот Улс дээр дурдсан бүх орнуудад зэвсэгт хүчнээ байрлуулсан байсан тул Коль уг үйл явцыг анхааралтайгаар ажиглан сууж болох байлаа. Гэтэл Коль өөрөө хөдөлж эхэлсэн юм. Тэрбээр 1989 оны 10-р сард “ 10 зүйл бүхий” хөтөлбөр эхлүүлсэн нь хоёр Герман улсыг нэгтгэх олон улсын үйл явцыг шийдвэрлэх хэмжээгээр урагшлуулсан юм. Тухайн үеийн нөхцөлд байдлаас гарахад түүний оюун ухаан, зөн мэдрэмжийн гайхалтай гялалзсан амжилт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Тэр хөтөлбөр тухайн үед гарч болох байсан, гарсан бүх алдаа оноог нарийн дэнсэлж чадсан юм.

Москва, Парис, Лондоны зүгээс эсэргүүцэлтэй тулгарах нь ойлгомжтой байсан нөхцөлд тэр тун эрсдэлтэй алхам хийсэн юм. Түүний санаачилга бүтэлгүйтсэн бол түүнийг буруутгах хүмүүс захаас аван тун олон байх нь эргэлзээгүй хэрэг. Ардчилал ийм л байдаг хойно. Хэрэв улс төрч амжилтад хүрвэл түүний зөв гэж үйл ажиллагааг нь баталдаг. Харин бүтэлгүйтвэл түүний сайн санаа, хүчин зүтгэлийг хэн ч үнэлдэггүй юм.

6.

Миний сүүлчийн жишээ бол Баадер-Майнхофын өөрсдийгөө Улаан-Армийн-Бүлэг гэж нэрлэдэг алан хядагч бүлэглэлийн эсрэг явуулсан хамгаалах тэмцлийн тухай юм. Тэр бол зөвхөн нэг удаагийн хэрэг биш, харин гурван засгийн газрын хуулийн хугацааг дамжин үргэлжилсэн олон удаагийн аймшигт хэрэг гарсан, эмгэнэлт явдал байлаа. 1972 онд Палестины исламын бүлэглэл Мюнхений олимпод Израилиас оролцсон баг тамирчдад халдсан халдлагыг тэдний урьдчилсан арга хэмжээ гэж нэрлэж болох бөгөөд ямар өндөр түвшинд, ямар аймшигтай гэмт хүч хуралдсаныг харуулсан юм. Брандт, Шээлийн засгийн газрууд уг гэмт халдлагаас амьд үлдсэн гурван алан хядагчдыг баривчилснаас 8 долоо хоногийн дараа тэднийг барьцаалагдсан онгоцны багийн гишүүд, зорчигчдоор сольсон юм.

Гурван жилийн дараа 1975 онд Улаан Армийн бүлэг Берлин хотноо Берлиний улс төрч Лоренцыг барьцаалж шоронд хоригдож буй зарим хорлон сүйтгэгчдийг суллахгүй бол түүнийг ална гэж заналхийлэхэд Бонн болон Берлин хотноо засгийн эрхийг баригчид зан суртахууны хүнд байдалд орж хоёр хэцүүгийн аль нэгийг сонгох сонголтыг хийх ёстой болсон юм. Баруун Берлиний хотын дарга асан Штүетц, Бонны сөрөг хүчний дарга асан Хэлмут Коль нар болон засгийн газрын тэргүүн миний бие хамтран Петер Лоренцын амь насыг аврахын тулд шоронд суугаа алан хядагчдыг гадаадад гаргах шийдвэр гаргаж Мюнхений шүүхийн гурван жилийн өмнө гаргасан шийдвэрийг давтсан юм. Энэ тохиолдолд бидэнд үндсэн хууль, библийн аль нь ч шийдвэр

гаргахад тусалж чадаагүй. Татгалзах, зөвшөөрөх аль нь ч боломжтой байлаа.

Харин хожим нь тун удалгүй би ноцтой алдаа гаргажээ гэдгээ ухаарсан юм. Бид маш ноцтой алдаа хийсэн бөгөөд энэ алдаатай шийдвэрийг гаргахад би ч оролцсон. Дахин хэзээ ч ийм алдааг давтаж ийм наймаалцлыг зөвшөөрөх ёсгүй. Зөвхөн суллагдсан алан хядагчид гэмт хэргээ үргэлжлүүлээд зогсохгүй алан хядагчид барьцааны хүн олоод авбал амжилтад хүрэх нь эргэлзээгүй гэдэг тооцоон дээр хүн барьцаалах гэмт хэргээ үргэлжлүүлэх болно. Энэ хожимдсон ухаарлынхаа дагуу хэдхэн долоо хоногийн дараа Стокгольм дахь манай улсын элчин сайдын яаманд халдаж дипломат ажилтнуудыг барьцаалахад нэн даруй огтхон ч эргэлзээгүйгээр ямар ч тохиолдолд барьцаалагчдын шаардлагыг биелүүлэхгүй байх шийдвэрийг гаргасан юм. Бундестагт суудалтай улс төрийн намуудын удирдлагууд ч миний шийдвэрийг дэмжсэн юм. 1977 онд миний сайн танил, тун их хүндэтгэдэг байсан Ханс Мартин Шлайрыг барьцаалахад мөн адилхан шийдвэр гаргасан юм. Бид маш их зардал, хүч заран байж Шлайрыг барьцаалсан гэмт хэрэгтнүүдийн нуугдсан газрыг олон долоо хоногийн турш хайсан юм. Хорлон сүйтгэгчдийг шинэ шинэ арга залиар саатуулан барьж цаг хожиж байлаа. Өнөөдөр бид нуусан газарт тун ойрхон очсон боловч нэгэн яльгүй азгүй тохиолдлоос болоод амжилтад хүрч чадаагүй гэдгийг бүгдээрээ мэддэг болсон. Ханс Мартин Шлайрын гэр бүлийн хувьд Шлайрын амьд явах үндсэн эрх бусад бүх үнэлэмжээс дээгүүр тавигдах ёстой гэдэг нь ойлгомжтой, мэдээжийн хэрэг байлаа. Эцэст нь тэдний гэр бүлийнхэн Карлсруэ дэх үндсэн хуулийн цэцтэй утсаар холбогдсон юм.

Үндсэн хуулийн шүүх ч үндсэн хуулийн дагуу өрхийн тэргүүн, эр нөхрийн төлөө, эцэстээ хорлон сүйтгэгчдийн тусын тулд шийдвэр гарга гэдэг шийдвэрийг гаргаж чадаагүй юм. Үндсэн хууль за, эсхүл үгүй гэдэг шийдвэрийг гаргахад тус болж чаддаггүй. Библи, философи ч мөн адил тус болдоггүй. Бид гагцхүү өөрийн оюун ухаан, дотоод зан суртахуун дээрээ тулгуурлан шийдвэр гаргах ёстой болдог.

Германы Улаан Армийн бүлэгт исламын алан хядагчид туслахаар ирж дүүрэн зорчигчтой онгоцыг зүүн Африк хүртэл, дараа нь Сомали хүртэл барьцаалж нисэх баг, зорчигчид нийтдээ ерэн хүнийг егүүтгэнэ гэж заналхийлж байсан тэр үед ч бид энэ шийдвэрээсээ буцаагүй юм. Бид солилцох саналыг хүлээн авахгүй байх шийдвэрээсээ буцаагүй юм. Гэхдээ би нэг талаас энэ эмгэнэлт жүжигт хаашаа ч хөдлөшгүйгээр, гэм буруутайгаар татагдан орсон гэдгээ сайн ойлгож байсан юм. Харин бидэнд Сомалиад аз тохиож амжилтад хүрсэн юм. Харамсалтай нь барьцаалагдсан Ханс Мартин Шлайрын амь насыг аварч чадаагүй юм.

Өнөөдөр 30 жилийн дараа 1977 оны намрыг эргэн дурсахад бид тэр үед буруу шийдвэр гаргажээ гэж надад бодогддоггүй юм. Бид ямар ч тохиолдолд Стокгольмд хоёр дипломатын амь насыг эрсдэхэд, Ханс Мартин Шлайрын амь нас эрсдэхэд буруутай гэдгээ би мэдэж байна. Би мөн Стокгольм дахь манай улсын элчин сайдын яам руу хүч түрэмгийлэн довтолсон тэр өдөр зөн совин, мэдрэмждээ найдан гаргасан гэмт хэрэгтнүүдэд бууж өгөхгүй байх миний шийдвэр хожим бидний үйл ажиллагааг тодорхойлдог болсныг мэдэж байна. Гэхдээ: Хэрэв хэн нэгэн өнөөдөр бид улсын эрх ашгийн тулд

тэр шийдвэрт хүрсэн гэж бичих юм бол дэндүү ерөнхий сонсогдоно. Бодит байдал дээр сэтгэл зүрхээ өвтгөн байж хувь хүний эрүүл саруул ухаан, хувь хүний зан суртахуундаа хөтлөгдөн уг шийдвэрийг би түмэнтээ дэнслэн байж гаргасан юм. Шашин шүтдэг, эс шүтдэг, Христосын шашинтан, эсвэл шашингүй хүн үү гэдгээс үл хамааран бүгдэд маань хэцүү сорилт байсан юм.

Хэрэв би дээр дурдсан онцгой тохиолдолд гаргасан зургаан жишээнээс дүгнэлт хийх ёстой бол тухайн цаг үед идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй улс төрчийн сэтгэл зүрх, оюун бодол шийдвэр гаргахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэдгийг дахин давтан хэлэх байна. Харин оюун ухаанаа шавхан дайчилж байж ухаалаг шийдвэрийг гаргадаг юм.

III.

Алдарт Макс Вебер 1919 онд Мюнхен хотноо тавьсан, Өнөөг хүртэл ач холбогдлоо гээгээгүй байгаа “Улс төр бол мэргэжил” сэдэвт илтгэлдээ “Улс төрчийн нүдэн баримжаа” гэдэг дэндүү ерөнхий гэмээр санааг анх оруулж ирсэн байдаг. Тэр мөн улс төрчид явуулж буй үйл ажиллагааныхаа үр дагаврын өмнө хариуцлага хүлээх ёстой гэж хэлсэн байдаг. Үнэн хэрэг дээрээ бид үйл ажиллагааныхаа зөвхөн хийсвэр, ерөнхий үр дагавруудын өмнө төдийгүй хүсээгүй дагалдах нөлөөллүүд, тухайн цаг үед урьдчилан харах боломжгүй байсан үр дагавруудын өмнө хариуцлага хүлээх ёстой гэж би боддог. Улс төрчийн үйл ажиллагааны зорилтууд моралын хувьд ч, зорилтуудыг биелүүлэхэд ашиглаж буй хэрэгслүүд ёс зүйн хувьд зөв зүйтэй байх ёстой.

Гэхдээ гарцаагүй өөрийн оюун ухаанд найдан гаргах цаг хугацаа тулгамдсан шийдвэрүүдэд зайлшгүй нүдэн баримжаа сайтай байх ёстой. Харин олон талаас нь дүгнэж цэгнэх цаг хугацаа хангалттай нөхцөлд бол нягт нямбай дүн шинжилгээ хийж нягт нямбай эргэцүүлэн бодох шаардлагатай. Энэ нүдэн баримжаа нь зөвхөн үнэхээр түгшүүртэй онцгой тохиолдолд шаардлагатай төдийгүй, (би та бүхэнд зургаан онцгой тохиолдлыг жишээ болгосон) ердийн өдөр тутмын хууль тогтоох явцад ч уг шаардлагатай. Татварын бодлого, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, эсвэл аль нэгэн цахилгаан станцыг шинээр барих шийдвэр, эсвэл шинээр авто машины зам тавих зэрэг ер нь гаргаж буй бүх шийдвэртээ оюун ухаанаа дээд зэргээр шавхан дайчилж нягт нямбай хандах учиртай.

Өөрөөр хэлбэл: Улс төрчид өөрийн оюун ухааныг шавхан дайчлаагүй бол үйл ажиллагаа, үйл ажиллагааныхаа үр дагаврын өмнө сэтгэл зүрхээрээ хариуцлага хүлээж чаддаггүй. Сайн санааны үүднээс хандсан, ямар нэгэн үзэл санаанд нийцүүлсэн гэдэг үндэслэл тэднийг хариуцлагаас хамгаалахгүй. Ийм учраас би Макс Веберийн хариуцлагын ёс зүйн шаардлагыг үзэл бодлын ёс зүйгээс дээрд авч үз гэдэг санааг эрхэмлэсээр ирсэн.

Харин бид олон хүн өөрийн үзэл бодлын улмаас улс төрд ордог, харин хэзээ ч ухаантай учраас улс төрд ордоггүй гэдгийг мэднэ. Гэхдээ бид зарим улс төрийн шийдвэр үзэл бодлоос эхтэй, оюунлаг эргэцүүллийн үр дүнд гардаггүй гэдгийг бас мэдэж байгаа. Гэхдээ бид саналаа өгч буй иргэдийн дийлэнх хэсэг нь улс төрийн сонголтоо хийхдээ үзэл

бодлын шалтгаануудыг урьтал болгодог, эсвэл тухайн үеийн сэтгэл хөдлөлөөрөө ханддаг болохоос ухаалаг эргэцүүллийн үндсэн дээр хийдэггүй гэдгийг мэднэ. Ийм л байдаг шүү дээ.

Гэхдээ би улс төрийн шийдвэр гаргалтын үндсэн хоёр элемент бол оюун ухаан ба үзэл бодол гэж олон арван жилийн туршид хэлсэн үг, бичсэн номондоо байнга дурдсаар ирсэн гэдгийгээ энэ дашрамд хэлэхийг хүсч байна. Харин би энэ дүгнэлт жинхэнэ ардчилсан нийгэмд та нарын сонсож, уншиж байгаа шиг тийм амар хялбар биш гэдгийг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Учир нь бодит байдал дээр, үндсэн хуульт ардчилсан төрийн дэглэмд хэрэв хэн нэгэн улс төрч ганцаараа улс төрийн шийдвэр гаргавал энэ нь үнэхээр онцгой тохиолдолд тооцогдоно. Ихэнх, бараг бүх тохиолдолд шийдвэрийг хэн нэгэн дангаараа бус харин хүмүүсийн олонх гаргадаг. Энэ зарчим бүх хууль тогтоолтонд ямар ч гажуудалгүйгээр мөрдөгддөг. Бүх хууль парламентын олонхоор батлагддаг. Харин энэ нь: Парламентад хууль тогтоогч олонхийг бүрдүүлэхийн тулд олон зуун хүн хуулийн нэг текст дээр санал нэгдэх хэрэгтэй болдог. Энэ нь үнэн хэрэг дээрээ төдийлөн ач холбогдолтой биш зүйл ч маш хүндрэлтэй болж зургаан зуун Бундестагийн гишүүнд хүргэхэд хүндрэлтэй байдаг. Ийм нөхцөлд олноо хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд, өөрийн фракцын хүлээн зөвшөөрөгдсөн удирдлагуудад даатган орхих нь олонтой. Харин чухал зүйлс дээр олон гишүүд эхэндээ маргашгүй үндэслэл бүхий өөр өөр бодолтой байх нь элбэг. Тэдэнтэй зөвшилцөж нэгдсэн байр сууринд хүрэхийн тулд тэднийг сонсож хамтран ажиллах хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл: Парламентын хууль тогтоох процесс, парламентын олонхын

шийдвэр гаргалт нь олон гишүүдийг харилцан буулт хийх чадвартай, хүсэлтэй байхыг шаарддаг. (Үүнийг германуудын угийн бичигт тэмдэглэх хэрэгтэй. Германчууд залхуу харилцан буулт гэж ярих дуртай улс.) Зарчмын хувьд харилцан буулт хийж чаддаггүй хүн, зарчмын хувьд харилцан буулт хийхийг хүсдэггүй хүн ардчилсан хууль тогтоолтод нэмэр бус нэрмээс болдог. Эцэст нь хэлэхэд харилцан буулт улс төрийн үйл ажиллагааны логикийн зөв тогтолцоо, тууштай байдлыг ямагт сааруулж байдаг ч гэлээ ардчилсан депутат иймэрхүү алдагдлыг цааргалалгүйгээр хүлээн авдаг байх хэрэгтэй.

Нийгэмд олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг хөндлөнгийн ажиглагчид, нэн ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд зарим тохиолдолд үнээ тугалын наймаа, “залхуу харилцан буулт” гэж нэрлэдэг. Тэд ямар ч моралгүй фракцын сахилга бат гэж эгдүүцдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх процесст байнгын шүүмжлэлтэй хандах нь сайн бөгөөд тустай хэрэг. Гэхдээ л: Харилцан буулт ардчиллын шаардлагын зөв зарчим хэвээрээ үлдэнэ. Учир нь аливаа хууль тогтоогч байгууллага, түүний гишүүн тус бүр өөрийнхөө байр суурийг хөдөлшгүй тууштайгаар хамгаалаад байх юм бол тухайн хууль тогтоогч байгууллага нийгмийг эмх замбараагүй байдал руу түлхэнэ. Гишүүн тус бүр нь хувийн шийдвэрээ хөдөлшгүй хамгаалаад байвал засгийн газар нь засаглах чадваргүй болно. Үүнийг парламентын гишүүн бүр, засгийн газрын гишүүн бүр мэддэг. Ийм ч учраас ардчилсан улс төрч бүр би харилцан буулт хийх ёстой гэдгээ мэддэг. Улс төрд шинжлэх ухаанаас өөр зарчим үйлчилдэг. Улс төрд бол би харилцан буултыг хийх ёстой. Бодит байдал

дээр гуравдагч этгээдийг хохироосон, ирээдүй хойч үеийг хохироосон өөдгүй харилцан буултууд хийгддэг. Заримдаа үүссэн асуудлыг бүрэн шийдэх чадваргүй дутуу дулимаг, тухайн цаг үед асуудлыг шийдсэн мэт харагддаг харилцан буултууд хийгддэг. Харилцан буулт хийх нь бөөрөнхийлөх гэж оролдохоос ялгаатай. Бөөрөнхийлөх байдлаар харилцан буултад хандах, нэн түрүүнд олон нийтийн санаа бодолд нийцүүлэхийн тулд бөөрөнхий байдлаар харилцан буултад хүрэх гэсэн оролдлого өдөр тутамд давтагдсаар байна. Иймээс харилцан буулт хийх хүсэлтэй улс төрчид өөрийнхөө оюун ухаанд найдахаас өөр аргагүй.

Улс төрчдийн сэтгэл зүрхтэй нь (дотор хүн нь зөвшөөрөхгүй учраас) зөрчилдөөд байгаа учраас хүлээн зөвшөөрч болохгүй харилцан буултууд байдаг. Ийм нөхцөлд санал зөрж буйгаа олон нийтийн өмнө хэлж ухаан бодлоо нээлттэй уралдуулах хэрэгтэй болдог. Мандатаа алдах, огцроход ч хүргэж болзошгүй. Харилцан буулт хийх чадваргүйгээр ардчилсан бодлого явуулах боломжгүй. Харин өөрийн санаа бодлын эсрэг шийдвэр гаргах нь тухайн улс төрчийн ёс зүй, зан суртахууныг гутааж, бусадтай хамтрах чадвартаа эргэлзэхэд хүргэдэг.

Миний тодорхойлсон хувийн шийдвэр гаргалтын орон зайн туйлуудыг миний бодлоор ухаантан ч гэсэн алддаг гэдгийг оролцуулбал улам илүү түгшүүртэй болох болно. Өөрийн логик сэтгэлгээ алдаж болно, эцэст нь өөрийн мэдрэмж оюун ухаан ч алдаж болно. Энэ тохиолдолд зан суртахууны зэмлэл хүртээх нь иш үндэслэлгүй юм. Харин энэ тохиолдолд улс төрч өөрийн алдаа эндэгдлийг хожим мэдсэн бол тэр

өөрийн алдаа, хожим танигдсан үнэнийг хүлээн зөвшөөрөх үү? гэдэг асуудалтай тулгарна. Ийм тохиолдолд улс төрчид эхний ээлжинд энэ ёслолын танхимд хуран цугласан хүн бүрийн нэгэн адил хүнийхээ хувиар ханддаг. Бидэнд бүгдээрэнд маань өөрийн оюун ухаан алдсаныг, цаашилбал өөрийн тухай үнэнийг олон нийтэд чангаар хэлэн хүлээн зөвшөөрнө гэдэг амаргүй. Зөвхөн улс төрчид ч биш бүх хүнд хэцүү.

Үнэний тухай асуултыг бүх авьяас чадал оюун ухаанаа дайчлах чадвараас ялгаж салгаж болно. Макс Вебер уг чанарыг улс төрчийн гурван гол шинж чанарын нэг гэж хэлсэн байдаг. Үнэний тухай асуулт бол илтгэх урлагийн чадвараас эрс өөр зүйл. Илтгэх урлагийг хоёр мянга таван зуугаад жилийн өмнө эртний Афин хотод хамгийн чухал урлагийн нэг гэж үзэж байсан нь өнөө үед ч хэвээр байна. Өнөөгийн телевизийн эрин үед илтгэх урлаг нь эртний Грекийн Афин хотын яармаг дээр урнаар илтгэхээс илүү чухал ач холбогдолтой болсон нь ойлгомжтой. Сонгогдохыг хүсэгч хүн бүр өөрийн хөтөлбөр, төсөөллийг олон нийтэд таниулах чадвартай байх ёстой. Гэхдээ тэд телевизийн үзэгчдэд таалагдах гэсэндээ өөрийн боломжоос хэтэрсэн амлалтуудыг өгөх аюултай гэдгийг мартаж болохгүй. Би нэг удаа нэг алдаатай, биелэгдэшгүй амлалтыг өгсөн юм. 1976 онд бид эдийн засгийн урьдчилсан таамаглал, тухайн үед хэрэглэгдэж байсан аргачлал дээр тулгуурлан нарийн шинжилгээ хийсний үндсэн дээр тэтгэврийг нэмэх боломжтой гэж үзэж байлаа. Харин тодорхой хугацааны дараа таамаглал хэтэрхий өөдрөг, оновчтой бус гэдэг нь тогтоогдсон юм. (Би энд дандаа муу амлаж явдаг сангийн сайд асан Ханс Апел

хүртэл байдлыг эерэгээр үнэлж байсан гэдгийг нэмж хэлмээр байна.) Ямартай ч бид дахин хянаж үзэх хэрэгтэй байсныг хянаагүй буруутай. Хожим нь тэтгэврийн худал амлалт өгсөн гэдэг моралын гэмшил олон жилийн дараа сэтгэлийн хөөрлөөр намайг зэмлэсэн энх тайвны хөдөлгөөнийхний зэмлэлээс хамаагүй илүү намайг зовоож билээ.

Сонгуульд өрсөлдөгч бүр хэтрүүлэг хэрэглэхээс өөр аргагүй байдалд ордог. Гадаад үзэмж, нэн ялангуяа телевизийн үзэгчдэд таалагдах өрсөлдөөн өмнөх сонин уншдаг байсан нийгэмтэй харьцуулахад илүү хүчтэй болжээ. Орчин үеийн өргөн олны ардчиллын үед Уинстон Черчиллийн хэлсэн шиг бодит ертөнц дээр, бидний хувьд ардчилал бол өнөөгийн болоод өнгөрсөн үеийн засаглалын бүх хэлбэрүүдтэй харьцуулахад засаглалын хамгийн сайн хэлбэр, нөгөө талаас огтхон ч идеал бус мөн бүрэн төгс бус засаглалын хэлбэр юм. Ардчилал олон төрлийн оролдлого, алдаа эндэгдэл, гажуудлаас ангид байх боломжгүй. Засгийн эрхийг баригчид нь засгийн газраа хүч хэрэглэлгүйгээр, цус урсгалгүйгээр шилжүүлэх боломжийг бүрдүүлдэг нь ардчиллын хамгийн том ололт мөн. Энэ нь засгийн эрхийг баригсад, парламентын олонхыг засаглуулагчдын (ард түмний өмнө) хариуцлага хүлээлгэх үндэс юм.

Макс Вебер улс төрчийн мэргэжилдээ хамаг сэтгэлээ өгсөн байх, нүдэн баримжаатай байхаас гадна хариуцлагаа ухамсарлах ухамсар бол улс төрчид байх ёстой үндсэн шинж гэж үзсэн байдаг. Миний хувьд бол надад саналаа өгч намайг сонгосон сонгогчид эцсийн шатны шүүх биш. Учир нь сонгогчид ерөнхий чиг хандлагын дагуу шийдвэр гаргадаг


бөгөөд ихэвчлэн мэдрэмжээрээ, олны аяыг харж байгаад шийдвэрээ гаргадаг. Үүний нэгэн адил олонхын шийдвэрт захирагдах зарчим нь улс төрчдийг дуулгавартай болгодог. Хувь хүний хувьд миний сэтгэл зүрх хамгийн дээд шатны шүүх мөн. Гэхдээ би: Сэтгэл зүрхний тухай философийн, шашны сургаалын байр сууриуд байдаг гэдгийг мэднэ. Сэтгэл зүрх гэдэг үг Грекүүд, Ромчуудын үед ч хэрэглэгдэж байсан. Хожим нь Паулус болон бусад шашны сургаал судлаачид бурхнаас хүмүүст өгсөн ухамсар гэж тодорхойлсон байдаг. Бурхны таалалд нийцсэн дэглэм, үүнээс улбаалан уг дэглэмийг зөрчвөл нүгэл болно гэх зэргээр тодорхойлсон байдаг. Зарим Христосын сүсэгтнүүд хүмүүсийн дотор орших бурхны дуу хоолой гэж тодорхойлсон нь бий. Харин Имануэл Кант , өнөөдөр бид түүний тухай олонтаа ярьсан, амьдралынхаа туршид өөрийн сэтгэл зүрхний үнэт зүйлсийн талаар эргэцүүлэн бодсон. Түүний эргэцүүлэлд бурхан ямар ч нөлөө үзүүлээгүй. Кант сэтгэл зүрхийг хүний дотоод сэтгэлд оршин буй дотоод шүүхийн ухамсар юм гэж тодорхойлсон. Миний бодлоор сэтгэл зүрх өөрийн оюун ухаанаас эхтэй , эсхүл бурхнаас өгсөн аль нь ч байлаа гэсэн бид бүгдээрээ сэтгэл зүрхтэй гэдэгт эргэлзэх хэрэггүй. Хэн нэгэн хүн Христосын, Мусульман, Үнэн алдартны шашны сүсэгтэн, үл танигдахуйн ухааныг номлогч, чөлөөт сэтгэгч үү? гэдгээс үл хамааран насанд хүрсэн хүн бүхэн сэтгэл зүрхтэй. Ямартай ч хувь хүн өөрийнхөө сэтгэл зүрх, дотоод хүнийхээ эсрэг зогсох үе байдаг. Гэхдээ энэ нь ховор тохиолдол. Түүнээс гадна хүний сэтгэл зүрх алдах нь бий.

Хатагтай, ноёд оо,

Мэргэжлийн улс төрчийн гучин жилийн амьдралаас өөрийн биеэр ухаарсан зарим нэгэн ухаарлаа та бүхэнтэйгээ хуваалцахыг оролдлоо. Миний энэ оролдлого бол олон талт бодит амьдралын тун хязгаарлагдмал өчүүхэн хэсэг юм. Би энэ илтгэлээрээ улс төр, философийн гэрэлт цамхгууд минь болох Карл Поппер, Макс Вебер, Марк Аурел, Цицеро, Аристотель, Конфуциос нартай өрсөлдөх гээгүй юм шүү. Би мөн дэлхийн шашнуудын алтан зарчмыг энгийн үгээр давтлаа. Германчууд уг зарчмыг тун энгийнээр нэгэн зүйр үгээр “Надад бусад хүмүүс хийгээсэй гэж хүсэхгүй байгаа зүйлээ бусдад өөрөө бүү хий” хэмээн илэрхийлсэн байдаг. Би улс төрчийн энх тайвны өмнө хүлээсэн категорийн болон зан суртахууны үүргийг хөндөлгүй орхилоо. Имануэл Кантын төлөөлж буй иргэдийнхээ үүрэг, зааварчилгаанд захирагдах категори, түүний гадаад бодлогын ач холбогдлын талаар дурдсангүй. Би эрх чөлөө, шударга ёсны үндсэн зарчмуудыг энгийнээр тодотголоо. Магадгүй би улс төрчдөөс шаарддаг буянт үйлс тэдний эр зориг, дотоод тайван байдлын талаар ярих ёстой байсан байх. Би улс төрчдийн дагаж мөрдөх үнэлэмжүүд, уг үнэлэмжүүдгүйгээр улс төр гэмт хэрэг болон хувирч болзошгүй талаар ч ярьж болох байлаа. Энэ бүх зайлшгүй яригдах ёстой үндсэн элементүүдийн оронд би улс төрчдийн оюун ухаан, сэтгэл зүрхийг онцлон ярихаар шийдсэн юм. Энэхүү илтгэлийн хүрээнд зөвхөн тодорхой хязгаарлагдмал хүрээнд ярих шаардлагатай гэдгийг та бүхэн ойлгоно гэдэгт итгэж байна.

Эцэст нь би та бүхэнд хоёр зүйлийг тодотгон хэлэхийг хүсэж байна. Энэ нь миний нэгдүгээрт нээлттэй нийгэм бүрийн, ардчилал бүрийн төгс бус байдал, ардчилсан бодлогын дутагдалтай талууд, ардчилсан улс төрчдийн алдаа дутагдал, тэд бусдын нэгэн адил сул талуудтай байдаг. Бид ардчилсан төрийн хэлбэрийг төгс хэлбэр гэж үзвэл энэ нь өөрөө урам хугарах, уур хилэнг бадраах ноцтой алдаанд хүргэнэ. Бодит байдал дээр аливаа ардчилалд сул талууд байдаг, эргэцүүлэн боддог иргэн бүр энэ сул талыг харж ойлгож явдаг. Харин хоёрдугаарт: Германчууд бид нэн шинэ үеийн бусдад төдийлөн гайхуулаад байхааргүй түүхээсээ ардчилалдаа туйлбартай үнэнч байх, ардчиллаа байнга шинэчлэх, ардчиллын дайснуудыг зоригтойгоор сөрөн зогсох ёстой гэдгийг сурсан билээ. Бид ардчиллын төлөө тэмцэлдээ эв нэгдэлтэй байх юм бол, зөвхөн үүний төлөө нэгдэж чадах юм бол “Эв нэгдэл-Эрх-Эрх чөлөө” гэдэг сайхан үгсийг амьдрал дээр бодитоор хэрэгжүүлж чадна.

Та бүхнийг тэвчээртэйгээр сонссонд их баярлалаа.



“ГЕРМАН ЕВРОПЫН ЦЭЭЖИНД, ГЕРМАН ЕВРОПТОЙ ХАМТ”

ХБНГУ-ын канцлер асан Хелмут Шмидтийн ГСДН-ын ээлжит их хурал дээр хэлсэн үг

2011 оны 12-р сарын 4



Хайрт нөхөд, хатагтай, ноёд оо,

Та бүхэн хувь хүний хувьд надтай холбогдолтой нэгэн дурсамжаар үгээ эхлэхийг минь зөвшөөрнө үү. Сигмар Гавриел, Франц-Вальтер Штайнмайер болон нам маань надад үг хэлээч гэж хүсэлт тавихад одоогоос 65 жилийн өмнө Локи (гэргий агсан нь) бид хоёр шалан дээр өвдөглөн сууцгаачихаад ГСДН-ын Хамбург дахь намын байрны нээлтийн ёслолын урилгын плакатыг зурж суусан маань санаанд дурайтал буусан юм. Гэхдээ би үгийнхээ эхэнд та бүхэнд нэгэн зүйлийг тодруулж хэлэх нь зүйтэй байх. Миний нас өндөр болсон учраас намын явуулж буй өнөөгийн бодлогыг сайлаад бас муулаад ч байх зүйлгүй болсон. Надад нэгдүгээрт мөн хоёрдугаарт ч тэр манай улс үндэстний хүссэн ч эс хүссэн ч хамтдаа байх тавилан заяатай Европын хамтын ажиллагааны орон зайд гүйцэтгэж буй үүрэг, ролийн талаар бодогдох болсоор удаж байна.

Үүний зэрэгцээ миний бие та бүхэнтэйгээ болон улс үндэстэнд нь азгүй явдал тохиолдоод байхад бидэнд, бүх Европынхонд хэлбэрэлтгүй эрх зүйт төрт, либерал, ардчилсан удирдлагын зам заагч луужингийн үлгэр жишээг үзүүлж чадсан хөрш Норвегийн төлөөлөгч Женс Столберг нартай энэ индрийг хуваалцах боломж олдсонд баяртай байна.

Энэ хооронд өтөл буурай болсон хүний жам ёсоор миний бодол асар урт орон зайд хөвөрч байдаг. Өнгөрсөн түүхийг ч тэр, итгэл найдвар, хүсэл тэмүүллийг тээгч угтах ирээдүйг ч тэр. Гэхдээ би саяхны нэг өдөр маш хялбархан асуултад тодорхой хариулт өгч чадаагүй юм.

Вольфганг Тиерзе надаас “Хэзээ нэг Герман орон хэвийн орон болох юм бэ?” гэж асуусан юм. Би түүнд “Герман орон ойрын ирээдүйд л лав хэвийн орон болж чадахгүй” гэж хариулсан юм. Хэвийн орон болох гэхээр манай орны аймшигтай, гэхдээ түүхэндээ нэг л удаа хийсэн алдаа маань том тээг болоод байгаа юм. Үүнээс гадна энэ жижигхээн мөртлөө олон улс үндэстэнд хуваагдсан тивдээ, хүн ам зүйн болоод эдийн засгийн хувьд хэт давамгай төв байршлыг эзэлдэг маань саад болоод байгаа юм.

Ингээд би өөрийн мэдэлгүй ярих ёстой “Герман Европын цээжинд - Герман Европтой хамт” гэдэг өргөн хүрээтэй бөгөөд ярвигтай сэдэв рүүгээ орчихлоо.

ЕВРОПЫН НЭГДЭХ ШААРДЛАГА БА ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

Хэдийгээр манай тивийн 40 орны зарим нэгд нь жишээлбэл:Итали, Грек, Германд улс үндэстнээ гэх ухамсар хожуу бэхэжсэн ч гэлээ ер нь манай тивийн бүх оронд хаа сайгүй байн байн цуст дайн гарч байлаа. Бид Европын энэ түүхийг Европын төв хэсгээс харах юм бол тойргийн төвөөс зах руу, захаас төв рүү чиглэсэн эцэс төгсгөлгүй дайн тулааныг хийсээр ирсэн байдаг. Энэ бүх дайны тулааны талбар нь тойргийн төв буюу тивийн төв байсаар ирж.

Тивийн төвд ноёлогчид, төрт улсууд, эсхүл ард түмэн хүчгүй байх үед нь тивийн захын хөрш орнууд нь хүч нь суларсан төв рүүгээ довтлон ирдэг байлаа. Хамгийн олон хүний амь

эрсэдсэн, хамгийн их эд материалын сүйтгэл дагуулсан дайн бол 1618-1648 оны хооронд 30 жил үргэлжилсэн, ихэнхдээ германы нутаг дэвсгэр дээр болж өнгөрсөн нэгдүгээр дайн байлаа. Герман улс тухайн үед газарзүйн хувьд төдийлөн тодорхой бус ойлголт байсан бөгөөд ерөнхийдөө герман хэлтний хүрээгээр хязгаарлагдаж байжээ. Хожим нь францчууд 14-р Луйсын удирдлага дор, дараа нь Наполеоны удирдлага дор тус тус довтолон ирсэн байдаг. Харин Шведүүд хоёр дахь удаагаа довтолон ирээгүй юм. Харин Англичууд, Оросууд олон удаа манай орныг довтолсон. Хамгийн сүүлд гэхэд оросууд Сталины удирдлага дор довтолон ирсэн.

Харин Европ тивийн төв дунд орших хаант улсууд эсхүл төрт улсууд хүчирхэг байсан үедээ, эсхүл өөрсдийгөө хүчтэй болчихлоо гэж үзсэн үедээ! эсрэгээрээ тойргийнхоо зах руугаа довтолдог байж. Эдгээр дайн тулааныг загалмайтны аян дайн гэж нэрлэдэг бөгөөд энэ дайн ч мөн түрэмгийлэх дайн байсан юм. Энэ дайн зөвхөн бага Ази, Иерусалимын эсрэг төдийгүй Зүүн Прус, өнөөгийн Балтикийн гурван орны эсрэг чиглэж байлаа. Харин шинэ цагт Наполеоны эсрэг хийсэн дайн, мөн Висмаркийн 1864, 1866, 1870/71 онуудад гурван удаагийн дайныг эдгээрт оруулан тооцож болно.

1914-1945 оны хооронд мөн 30 жил үргэлжилсэн дайн ч эдгээрийн нэгэн адил. Нэн ялангуяа Гитлерийн Хойд Капаас Кавказ, Кавказаас Грекийн Крит арал, тэгээд өмнөд Франц, тэр ч байтугай Ливи-Египет улсын хилийн ойролцоох Товрук хүртэл үргэлжилсэн түрэмгийлэх дайн. Герман улсын өдөөсөн дайны уршгаар Европ тив сүйрэлд автаж Европын Еврейчүүд, Герман үндэстний төр улсыг сүйрэлд автсан юм.

Гэхдээ үүний өмнө Польшууд, Балтикийн улс үндэстнүүд, Чехүүд, Словакууд, Австричууд, Унгарчууд, Словенчууд, Хорватууд бүгдээрээ Европ гэдэг жижигхэн тивийнхээ төв дунд нь буюу цээжинд нь төрсөн хувь заяаныхаа төлөө хэдэн зууны туршид германчуудтай адилхан хувь заяаг туулсан билээ. Өөрөөр хэлэх юм бол: Германчууд бид өөрсдөө ч тивийнхээ төв байрлалд заяасных нь төлөө бусад улс үндэстнүүдийг олон удаа зовлонд учруулсан.

20-р зууны эхний хагаст улс үндэстнүүдийн ухамсарт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байсан хоорондоо зөрчилтэй газар нутгийн маргаан, хэл ба хил хязгаарын зөрчил өдгөө бодит байдал дээр ач холбогдлоо гээсэн байна. Ямартай ч германы хувьд төдийлөн ач холбогдолгүй болжээ.

Европын улс үндэстнүүдийн олон нийтийн санаа бодлын болон хэвлэгдсэн санал бодлын ухамсарт дундад зууны үед болж өнгөрсөн дайны талаархи мэдлэг, дурсамж шинэ сэргэг зүйл биш болсоор удсан ч 20-р зуунд болж өнгөрсөн дэлхийн хоёр дайн, Германы эзэмшилд байсан үеийн дурсамжууд далд байдлаар давамгайл рольтой хэвээрээ үлдчихжээ.

Тэгэхлээр миний бодлоор германчууд бид Германы бараг бүх хөрш орнууд, энэ дэлхийн бүх еврейчүүд Германы эзэмшлийн үед тойргийн захад болж өнгөрсөн их сүйтгэл, ичгүүртэй явдлыг эргэн дурсан санасаар байгаа гэдгийг мартаж учиргүй. Германчууд бид өөрсдөө манай бараг бүх хөрш орнууд, тэр ч байтугай олон үеийнхээ туршид германчуудыг яах гээд байна даа? хэмээн сэжиглэсэн харцаар харсан хэвээрээ байх болно гэдгийг сайн ойлгодоггүй.

Ирээдүйд төрөх ач үрс маань ч түүхийн энэ ачааг үүрсээр амьдрах болно. Өнөө үеийнхэн бидний мартаж болохгүй, санаж явах ёстой зүйл бол: 1950-иад оны үед Европын нэгдлийн эхлэлийг тавьсан шалтгаан нь герман орон ирээдүйд эрчимтэй хөгжиж дахин хүчирхэгжиж болзошгүй гэдэг сэжиг хардлагаас үүдэлтэй юм шүү.

1946 онд Черчилл Цюрих хотноо хэлсэн алдарт үгэндээ дараахи хоёр шалтгааны улмаас францчуудыг германчуудтай эв зүйгээ олж, германчуудтай хамтдаа Европын Нэгдсэн Улсыг байгуулахад уриалан дуудсан юм. Нэгдүгээрт тухайн үед заналхийлээд байгаа мэт сэтгэгдлийг төрүүлж байсан Зөвлөлт Холбоот Улсаас хамтдаа хамгаалах, Хоёрдугаарт: Германыг Барууны том холбоонд уяж авах. Учир нь Черчилл Герман улс дахин хүчирхэгжинэ гэдгийг урьдчилан харж байсан юм.

1950 онд Черчиллийг алдарт үгээ хэлснээс хойш 4 жилийн дараа Роберт Шүманн, Жан Моне нар баруун Европын хүнд үйлдвэрүүдийг нэгтгэх тухай Шүманны төлөвлөөг боловсруулсан нь мөн л Германыг барууны холбоонд уяж авах зорилгыг агуулж байлаа. 10 жилийн дараа Шарль Де Голль Конрад Аденаурт эвлэрлийн гар сунгахдаа мөн л адилхан зорилго агуулж байлаа.

Энэ бүхэн бүгдээрээ герман орон дахин хүчирхэгжиж магадгүй бөгөөд тэр нь нэг л айдас дагуулаад байсан учраас бодит байдалд нийцүүлсэн хийсэн алхмууд байлаа. 1849 онд Европ нэгдэгтүн! хэмээн уриалсан Виктор Нүгогийн идеализм болон бусад идеализмуудын аль нь ч 1950/52

оны үед тухайн үед зөвхөн баруун Европоор хязгаарлагдаж байсан Европын нэгдэл үүсэх үед хүчтэй байгаагүй. Тухайн үеийн Европ болон Америкийг удирдаж байсан төрийн харчуул (Би энд Жорж Маршал, Айзенхаур, мөн Кеннеди, гэхдээ юуны өмнө Черчилл, Жан Моне, Аденаур, Де Голль эсхүл Гаспери, Хенри Спаак нарыг нэрлэж байна.) ямар ч тохиолдолд Европын идеализмын үүднээс Европын нэгдэлд хандаж байгаагүй, харин тэдний үеийг хүртэл Европын туулж ирсэн түүхийн сургамж дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж байсан юм. Тэд тойргийн захаас тойргийн суларсан төв болох германы эсрэг дайн гаргуулахгүй байхад бодит үйл ажиллагаагаа чиглүүлж байсан юм. Өнөөг хүртэл Европын нэгдлийн тулгуур багана нь болсоор байгаа энэхүү анхдагч учир шалтгааныг ухаж ойлгоогүй хүн бүр өдгөө асар ярвигтай болчихоод байгаа Европын хямралыг шийдвэрлэх амин чухал нэгэн нөхцөлийг мэдэхгүй байна гэсэн үг.

1960, 70, 80-аад оны үед Холбооны Бүгд Найрамдах Герман Улс эдийн засаг, батлан хамгаалах, улс төрийн салбарт улам бүр хүчирхэгжиж ач холбогдол нь өссөөр байсан тэр үед баруун Европын орнуудын төрийн жолоог атгагчдын нүдэнд германчууд эрх мэдэл бодлогын хувьд дахин асар хүчирхэг болохын цагт тэднийг толгой дээрээ гаргахгүй байхын тулд Европын нэгдэлд уяж авахаас өөр найдвартай ар тал байхгүй мэт харагдаж байсан юм. 1989/90 оны үед дайны дараа тусгаар болчихсон хоёр Германы дахин нэгдэх үйл явцын эхэн үед Маргарет Тетчер, Миттеран, Андреоттис нар эсэргүүцээд байсан нь жижигхэн Европ тивийн цээжинд оршдог Герман улс дахин хүчирхэгжих бий гэдэгт санаа зовсондоо тэгсэн хэрэг.

Би энд хувь хүнийхээ хувьд үзэж харсан зүйлээсээ дурсах зөвшөөрлийг өөртөө олгочихъё. Би Монегийн тэргүүлдэг "Poor les États-Unis d'Europe"-хорооны хуралд оролцож байхдаа түүний хэлсэн үгийг сонсоод сууж байлаа. 1955 онд юмдаг. Жан Моне миний амьдралдаа танилцсан бүх француудын дотроос хамгийн их алсын хараатай франц эр гэдгээрээ сэтгэлд минь хоногшин үлдсэн. Европын нэгдлийн тухайд, мөн алхам алхмаар нэгдэх нь зүйтэй хөтөлбөр нь тун алсын хараатай байсан юм.

Тэр үеэс хойш би Герман үндэстний стратегийн ашиг сонирхлын төлөө, харин аль нэгэн идеализмын үүднээс бус, Европын нэгдлийг дэмжигч, Германыг Европтой уяхыг дэмжигч болсон бөгөөд тэр хэвээрээ үлдсэн юм.

(Ийнхүү дэмжигч болсон маань намайг Күрт Шүмахерын хувьд ялимгүйд тооцогдох, харин 30 настай дайнаас эргэн ирсэн залуу эр миний хувьд маш их хүндэтгэлтэй ханддаг намын даргатайгаа ноцтойгоор санал зөрөлдөхөд хүргэж билээ.) Энэ бодол маань 1950-иад оны үед тухай үеийн Польшийн гадаад хэргийн сайд асан Рапакигийн төлөвлөгөөг дэмжихэд хүргэсэн юм. 60-аад оны эхэн үед барууны албан ёсны цөмийн стратегийг эсэргүүцэж нэгэн ном бичсэн юм. Тухайн үед хүчирхэг ЗХУ-д заналхийлээд байсан НАТО-гийн эсрэг, өнөөдөр ч бид НАТО-гийн холбоотон хэвээрээ л байна.

ЕВРОПЫН ХОЛБОО БИДЭНД ХЭРЭГТЭЙ.

Де Голль, Помпидоу нар Германыг уяж авахын тулд 1960-аад он, 1970-аад оны эхэн үеэр Европын холбоог үргэлжлүүлсээр байлаа. Тэгсэн хэрнээ тэд өөрсдийнхөө орныг Европ тивийн мандах ба буурахтай холбохыг хүсэхгүй байлаа. Үүний дараагаар Жискар де Эстен бид хоёр сайн ойлголцдог байсны хувьд франц-германы хамтын ажиллагааны үеийг эхлүүлж улмаар Европын нэгдлийг урагшуулж байлаа. Хожим нь Миттеранд, Коль нар 1990-ээд оны хавраас эхлэн энэ харилцааг амжилттай үргэлжлүүлсэн юм. 1950/52 оноос 1991 оны хооронд Европын хамтын нийгэмлэг алхам алхмаар өргөжсөөр зургаан гишүүнээс 12 гишүүн оронтой болтлоо тэлсэн юм. Жак Делорын өргөн хүрээтэй бэлтгэл ажлын ачаар (Тухай үед Европын комиссын ерөнхийлөгч байсан) Миттеран, Коль нар 1991 онд Маастрихт евро нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэвтрүүлэх тухай ярилцсан ч энэ нь 2001 онд арван жилийн дараа биеллээ олсон юм. Үүний цаад учир шалтгаан нь герман орон хэт хүчирхэг болчих бий гэдэгт санаа зовнисон хэрэг. Илүү тодорхой хэлэх юм бол: Д-марк хэт хүчирхэг болчих бий гэдгээс айсандаа тэгсэн хэрэг.

Энэ хооронд ЕВРО дэлхийн эдийн засгийн хоёрдогч чухал мөнгөн тэмдэгт болсон байна. Европын энэхүү мөнгөн тэмдэгт дотооддоо ч мөн гадаад харьцаанд ч америк доллараас, мөн Д-марк сүүлийнхээ арван жилд байснаас ч илүү тогтвортой байна. Евро хямарлаа гэж бичээд, яриад байгаа зүйл бүгд худал. Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид, улс төрчид зүгээр л амны зугаа болгож байгаа дэмий яриа.

1991/92 онд Маастрихын гэрээ байгуулагдсанаас хойш дэлхий ертөнц асар хурдацтай өөрчлөгджээ. Бид энэ хооронд зүүн Европын орнууд чөлөөлөгдөхийг, ЗХУ задрахыг нүдээрээ харсан гэрчүүд болцгоолоо. Бид мөн өмнө нь бүхэлд нь багцлаад “Гуравдагч ертөнц” гээд нэрлэхихдэг байсан Хятад, Энэтхэг, Бразил болон бусад “Босго буюу хөгжингүй” орнуудын үсрэнгүй хөгжлийн гэрчүүд болцгоолоо. Мөн энэ хугацаанд дэлхийн томоохон хэсгийн улс ардын аж ахуйнууд “даяарчлагдаж” германаар хэлэх юм бол “дэлхийн бараг бүх орнууд харилцан бие биенээсээ хамааралтай болжээ. Юуны өмнө даяаршсан санхүүгийн зах зээлийн актёрууд түр зууртаа хяналтаас ангид эрх мэдлийг олсон байна.

Харин үүний зэрэгцээ, бараг мэдэгдэлгүйгээр хүн төрөлхтөн тэсрэлтийн хурдаар өсөн нэмэгдэж 7 тэрбумд хүрээд байна. Намайг төрж байхад дөнгөж 2 тэрбум байсан юм. Энэ бүх үсрэнгүй өөрчлөлтүүд Европын ард түмэн, төрт улсууд тэдгээрийн хангалуун амьдралд гүнзгий өөрчлөлтүүдийг авчирчээ.

Нөгөө талаас Европын улс үндэстнүүдийн хүн ам насжиж байна. Хаа сайгүй хүн амын тоо буурч байна. 21-р зууны дунд үе гэхэд хүн төрөлхтөн эх дэлхий дээрээ 9 тэрбумаараа хамтран амьдрах болох нь. Харин Европын хамаг улс үндэстний хүн ам нийлээд дэлхийн хүн амын зөвхөн 7 хувьд хүрэхтэй үгүйтэй болох нь. 9 тэрбум хүний зөвхөн 7 хувь гээд боддоо!. 1950 оныг хүртэл Европчууд хоёр зуу гаруй жилийн туршид дэлхийн хүн амын 20 хувийг эзэлдэг байсан юм. 50 жилийн тэртээгээс Европчууд бид зөвхөн үнэмлэхүй тоогоор төдийгүй Ази, Африк, Латин Америк тивтэй харьцуулсан

харьцаагаар, мөн түүнчлэн дэлхийн нийгмийн бүтээгдэхүүнд эзэлж буй хувь хэмжээгээр буюу нийт хүн төрөлхтний орлогоос хувь хүртэх хэмжээгээрээ буурсаар байна. Энэ үзүүлэлт 2050 оныг хүртэл дахин 10 хувиар буурна. 1950 онд ойролцоогоор 30 хувь байсан юм.

Европын улс үндэстнүүдийг тус тусад нь авч үзвэл тэд 2050 он гэхэд дэлхийн хүн амын нэг хувийн ... хувьтай буюу 0 бүхэл зууны, мянганы тэдэн хувьтай тэнцэх болно. Энэ нь юу гэсэн үг бэ? гэхлээр: Европчууд дэлхий дахинд жаахан ч гэсэн ач холбогдолтой байхыг хүсэж байгаа юм бол бид зөвхөн хамтдаа байх ёстой. Франц, Итали, Герман, эсхүл Польш, Голланд, Дани, Грек аль нь ч байлаа гэсэн биднийг эцэст нь бүхэл хувиар бус харин мянганы тэд гэдэг тоогоор л хэмжих болно.

Чухам энэ харьцаан дээр Европын улс үндэстнүүдийн нэгдсэн холбоонд нэгдэх урт хугацааны ашиг сонирхол нэгдэж байгаа юм. Европын холбоонд нэгдэх энэхүү стратегийн ашиг сонирхол нь эргэх цагийн явцад улам их ач холбогдолтой болсоор байх болно. Энэ л учир шалтгааныг улс үндэстнүүд өнөөг хүртэл төдийлөн ухамсарлахгүй байгаа юм. Үүнийг ухамсарлуулах талаар засгийн газрууд нь ч ажиллахгүй байгаа юм.

Хэрвээ ирэх арван жилийн хугацаанд Европын холбоо хязгаарлагдмал ч болтугай хамтарсан үйл ажиллагааны чадавхыг бий болгож чадахгүй юм бол Европын улс үндэстнүүд өөрсдийнхөө муугаас Европын соёл иргэншлийг буланд шахагдахад хүргэж болзошгүй. Ингэсэн тохиолдолд

Европын улс үндэстнүүд хоорондын болон нэр алдрын төлөөх өрсөлдөөн дахин сэргэх нь ойлгомжтой. Тойргийн төвөөс зах руу, захаас төв рүү чиглэсэн хуучны тоглоом ч дахин сэргэх болно.

Даян дэлхийд соён гэгээрүүлэх, хүн бүрийн эрх, халдашгүй дархан байдал, эрх зүйт төрт ёсыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт Европын зүгээс шинэ эрч хүч, санаа оноо нэмэгдэхгүй болно. Энэ бүх хүчин зүйлсийг харгалзан үзэхэд Европын хамтын нийгэмлэг нь манай хуучин тивийн улс үндэстнүүдийн амьдралын зайлшгүй шаардлага юм. Амьдралын энэхүү зайлшгүй шаардлага нь Черчиль, Де Голльоос эхлээд Моне, Аденаурын шаардлагаас эхтэй юм. Эдгээрт Эрнст Ройтерс, Фритц Эрлерс, Вилли Брандт, Хэльмут Коль нарын шаардлагууд ч багтаж буй.

Дээрээс нь би нэмээд: Европын нэгдэлд Германыг уях сонирхол үргэлжилсээр байгаа гэдгийг хэлчихье. Иймээс германчууд Европын холбооны хүрээнд ямар үүрэг, рольтой байх бэ? гэдэг талаараа өөрсдөө тодорхой ойлголттой байх ёстой.

ГЕРМАНЫ БОДЛОГО ТОГТВОРТОЙ, ИТГЭЛТЭЙ БАЙХ ЁСТОЙ.

Хэрэв бид 2011 оны эцсээр Германыг шууд хиллэдэг болон дам хиллэдэг хөрш орнуудынхаа нүдээр гаднаас нь харвал сүүлийн арван жилд манай орон нэг л аягүй харагдаж байгаа. Сүүлийн үед улс төрийн хувьд санаа зовоосон улс болоод байгаа. Сүүлийн жилүүдэд Германы бодлогын тогтвортой байдалд эргэлзэх болжээ. Германы бодлогод итгэх итгэл суларч байна.

Эдгээр эргэлзээ, санаа зовнил нь Германы улс төрчид, засгийн газруудын гадаад бодлогод гаргасан алдаанаас эхтэй. Мөн зарим талаараа ХБНГУ-ын дэлхий дахиныг гайхшруулсан эдийн засгийн хүчирхэг байдлаас ч эхтэй. Манай орны улс ардын аж ахуй 1970-аад оны эхнээс тухай үед хоёр хуваагдчихсан байсан ч гэлээ Европын хамгийн том улс ардын аж ахуй болтлоо хөгжсөн юм. Манай улсын улс ардын аж ахуй технологи, санхүү болон нийгмийн бодлогын хувьд дэлхийн хамгийн өндөр бүтээмжтэй улс ардын аж ахуйн нэг болтлоо хөгжсөн. Бидний хүчирхэг эдийн засаг, хэдэн арван жилийн туршид харьцангуй тогтвортой байгаа нийгмийн амгалан тайван байдал бусдын атаархлыг төрүүлж байна. Мөн манай улсын ажилгүйдлийн коэффициент, төсвийн алдагдал зэрэг нь олон улсын түвшинд аваад үзэхэд хэвийн хэмжээнд байгаа юм.

Гэхдээ бид манай улсын эдийн засаг бүхэлдээ Европын нэгдсэн зах зээлд өндөр түвшинд нэгдсэн, мөн төдий хэмжээний өндөр түвшинд даяаршсан, үүгээрээ дэлхийн эдийн засгийн байдлаас хараат гэдгийг хангалттай хэмжээнд ухамсарлахгүй байна. Ийм ч учраас ойрын жилүүдэд германы экспорт төдийлөн дорвитой өсөхгүй гэдгийг бид харах болно.

Үүний зэрэгцээ манай улсын худалдааны тэнцэтгэл, бүтээмжийн тэнцэтгэл тогтмол их хэмжээний илүүдэлтэй байдаг гажуудалтай хөгжил нутагшиж байна. Энэ илүүдэл олон жилийн туршид манай улсын нийгмийн бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэж байна. Манай улсын илүүдэл ойролцоогоор Хятадын илүүдэлтэй тэнцэж байна. Эдгээр илүүдэл Д-маркаар бус еврогоор хэмжигдээд байгаа учраас бид төдийлөн

анзаарахгүй байгаа юм. Гэхдээ үүнийг манай улс төрчид сайтар мэдэж байвал зохилтой.

Учир нь манай улсад илүүдээд байгаа бүхэн бусад орнуудад дутаж байгаа. Бусад орнуудад бид өрөө бууруул гэдэг шаардлагыг тавьдаг. Эдгээр илүүдэл нь нэгэн цагт бидний эрхэм зорилго болгон хуульчилсан “гадаад эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах” зарчмыг маань алдагдуулаад байгаа юм. Хуульчилсан зарчмаа гажуудуулж байна хэмээн манай түншүүд ундууцах ёстой юм. Сүүлийн үед гадаадын тэр дундаа Америкийн дуу хоолой ихэвчлэн сонсогдоод байдаг байсан бол энэ хооронд илүү олон талаас сонсогдох болж тэд Герман Европт тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг шаардах болсон нь манай хөршүүдэд илүү их сэжиг төрүүлээд байна. Энэ нь тэгээд хуучны таагүй дурсамжуудыг сэргээгээд байна.

Энэхүү эдийн засгийн хөгжил, Европын Холбооны байгууллагуудын үйл ажиллагааны чадамжын хямралтай хослохоороо Германыг дахин төвийн тоглогчийн үүрэг гүйцэтгэ гэж шахаанд оруулахад хүргээд байна. Манай канцлер Францын ерөнхийлөгчтэй хамтраад энэ үүргийг дуртайяа хүлээгээд авчихсан. Гэтэл Европын зарим орнуудын нийслэл хотод болон зарим орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Герман давамгайлаад байгаад санаа зовнисон байдал газар аваад байна. Энэ удаад цэргийн болон улс төрийн хэт давамгай эрх мэдлийн төвлөрөл бус харин хэт давамгай хүчирхэг эдийн засгийн төвлөрөл бий болж байгаад сэтгэл зовницгоож байна!.

Энд нухацтай, нягт нямбай хандах ёстой гэдэг сануулгыг

германы улс төрчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон олон нийтийн санаа бодолд өгч байна.

Хэрвээ германчууд бид бусдын үгэнд орж эдийн засгийн хүчирхэг давуу тал дээрээ суурилоод Европод улс төрийн тэргүүлэх ролийг эзэгнэхийг санаархах, үгүй юм гэхэд *primus inter pares*-ийн дүрд тоглохыг оролдовол манай хөрш орнуудын дийлэнх олонх нь үүний эсэргүүцэж хамгаалалтын байр сууринд шилжих болно. Тойргийн захын орнуудын Европ тивийн төв хэт хүчирхэгжих бий гэдэг санаа зовнил тэр дороо сэргэх болно. Иймэрхүү хөгжлийн үр дагавар Европын Холбоог эрэмдэг зэрэмдэг болгох болно. Герман орон ч тусгаарлагдах аюулд орно.

Маш том бөгөөд бүтээмжийн өндөр чадавхи бүхий ХБНГУ-д өөрөөсөө өөрийгөө хамгаалах хамгаалалт хэрэгтэй!. Герман улс Европын холбооны хүрээлэл дунд орших ёстой. Иймээс Хэлмут Колийн үеэс буюу 1992 оноос үндсэн хуулийн 23-р зүйлд “Европын Холбооны хөгжилд...” хамтран зүтгэх үүргийг ногдуулсан. Түүнчлэн мөн үндсэн хуулийн 23-р зүйл бидэнд “Хүчтэй нь хүчгүйгийнхээ төлөө хариуцлага хүлээх...” үүргийг ногдуулсан байдаг. Европын Холбооны байгууллагуудын үйл ажиллагааны чадамжийн өнөөгийн хямралаас болж дээрх үндсэн зарчмууд өөрчлөгдөхгүй нь лавтай.

Манай улсын геополитикийн төв байршил, дээрээс нь нэмээд 20-р зууны дунд үеийг хүртэлх Европын түүхэнд бидний гүйцэтгэсэн сайнаасаа илүү саар үүрэг, дээрээс нь манай улсын бүтээмжийн асар өндөр чадавхи эд бүгд нийлээд манай улсын үе үеийн засгийн газруудаас ЕХ-ны түншүүдийнхээ ашиг сонирхолд маш мэдрэмжтэй хандах

чадварыг шаардаж байгаа юм. Бидний бусдад туслахад бэлэн байх чадвар онцгой чухал.

Германчууд бидний сүүлийн жаран жилийн асар их бүтээн байгуулалтыг дангаараа, өөрийн хүчээр хийгээгүй юм. Бидний энэ амжилт барууны ялсан гүрнүүдийн туслалцаагүйгээр, Европын хамтын нийгэмлэгийн хүрээлэлгүйгээр, Атлантын холбоотнуудгүйгээр, хөрш орнуудын туслалцаагүйгээр, дундад Европын зүүн хэсэгт улс төрийн сэргэн мандалт гараагүй бол, коммунист диктатур төгсгөл болоогүй бол боломжгүй байсан билээ. Германчууд бид үүнд баярлаж явах ёстой. Үүний зэрэгцээ бид бусдаас авсан эв санааны туслалцааг нэр төртэйгээр хариулах, хөрш орнуудтайгаа эв санааны нэгдэлтэй байх үүрэгтэй!

Үүний оронд дэлхийн улс төрд өөрийн орны гүйцэтгэх ролийг нэмэгдүүлэх, дэлхийн бодлогод нэр хүндээ өсгөх идэвх чармайлт гарган ажиллах нь ашиггүй, ашиггүйгээр барахгүй хохиролтой юм. Аль ч үед Франц, Польш оронтой, бүх хөрш орнууд, Европ дахь түншүүдтэйгээ нягт хамтран ажиллах нь зайлшгүй шаардлага юм.

Миний итгэл үнэмшлээр Германы амин чухал, стратегийн ашиг сонирхол өөрийгөө тусгаарлахгүй, бусдаар тусгаарлуулахгүй байхад оршино. Барууны дунд тусгаарлагдах нь аюултай. Европын Холбооны дунд тусгаарлагдах эсхүл Еврогийн орон зайн дунд тусгаарлагдах нь үүнээс ч илүү аюултай. Миний хувьд Герман улсын энэхүү ашиг сонирхол бүх улс төрийн намуудын тухай үеийн тактикийн ашиг сонирхлоос хамаагүй дээгүүр оршдог.

Германы улс төрчид, германы хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ашиг сонирхлын дээрх дэс дарааллыг олон нийтийн санаа бодолд тогтвортойгоор суулгаж өгөх чухлаас чухал үүрэгтэй бөгөөд өртэй.

Хэрвээ хэн нэгэн өнөөдөр Европ өнөө болоод ирээдүйд германаар ярих болно гэдэг ойлголтыг өгч суугаа бол, хэрвээ Германы гадаад хэргийн сайд Кайро эсхүл Кабул, Триполид телевизийн нэвтрүүлэгт оролцох нь Лиссабон, Мадрид, Варшав эсхүл Прага, Дублин, Ден Хааг, Копенгаген, эсхүл Хельсинкитэй холбогдохоос илүү ач холбогдолтой гэж үзэж байгаа бол, эсхүл хэн нэгэн нь Европын "Шилжилтийн холбоо"-г хамгаалах ёстой гэж үзэж байгаа бол энэ бүгд зүгээр л биеийн хүчээрээ бардамнан сайрхаж байгаа хүнтэй адилхан.

Бодит байдал дээр Герман улс олон арван жилийн туршид цэвэр төлөгч байсан. Бидэнд үүнийг төлөх хүндрэлтэй ч байгаагүй, Аденаурын үеэс л төлсөөр ирсэн. Мэдээж хэрэг, Герк, Португали, эсхүл Ирланд улсын хувьд байнга л цэвэр авагч байсаар ирсэн.

Энэхүү эв санааны нэгдэл Германы улс төрийн өнөөгийн ангийнхны ухамсарт хангалттай суугаагүй байж болох юм. Харин өнөөг хүртэл үүнд хэн ч эргэлзэж байгаагүй юм. Үүнтэй нэгэн адил ойлгомжтой бөгөөд Лиссабоны гэрээнд заачихсан зүйл бол хүчтэй нь хүчгүйнхээ төлөө хариуцлага хүлээдэг зарчим юм. Төрийн зохицуулж чадахгүй байгаа эсхүл хүч нь хүрэлцэхгүй байгаа зүйлийг Европын Холбоо өмнөөс нь зохицуулж өгөх учиртай.

Шүманны төлөвлөгөөний үеэс Конрад Аденаур өөрийнхөө улс төрийн зөв совин мэдрэмжээ дагаж Күрт Шүмахерыг эсэргүүцсээр байхад хожим нь Людвиг Эрхардсыг эсэргүүцсээр байхад Францын саналыг хүлээн авсан. Аденаур Германы урт хугацааны стратегийн ашиг сонирхлыг хэдийгээр тухайн үед нь Герман хоёр хуваагдчихсан байсан ч гэсэн зөв тодорхойлсон юм. Түүнийг залгамжлагчид Вилли Брандт, Шмидт, Коль, Шройдер нар Аденаурын нэгдэх бодлогыг үргэлжлүүлсэн юм.

Өдөр тутмын, дотоод бодлогын, гадаад бодлогын тактикийн бүх асуудлууд хэзээ ч Германы урт хугацааны стратегийн ашиг сонирхлын өмнүүр орж байгаагүй юм. Тийм ч учраас манай бүх хөрш орнууд, түншүүд олон арван жилийн туршид Германы Европын талаар баримталдаг бодлогын тогтвортой байдалд ямар засгийн газар эрх барьж байгаагаас үл хамааран итгэж чаддаг байсан юм. Бодлогын энэхүү тогтвортой байдлыг ирээдүйд ч хэвээр хадгалах учиртай.

ЕХ-НЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЭРЧИМТЭЙ АЖИЛЛАХЫГ ШААРДАЖ БАЙНА.

Герман улс концепцын шинжтэй хувь нэмэр оруулсаар ирсэн, үүнд бусад нь эргэлздэггүй байлаа. Ирээдүйд ч энэ хэвээрээ байх учиртай. Ингэхдээ бид хэт алсын ирээдүйг харсан зүйлийг хийх гэж улайрах хэрэггүй юм. Гэрээг яаж ч өөрчиллөө гэсэн хорин жилийн өмнө Маастрхт болон үйл явдал, орхигдуулсан зүйлс, алдааны зөвхөн тодорхой хэсгийг л засаж залруулж чадна. Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Лиссабоны гэрээг өөрчлөх тухай өнөөгийн санал нь бүх улс

үндэстнүүд Европын нэгдсэн үндсэн хуулийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурах явцад учирсан хүндрэлүүд, мөн сөрөг үр дүнтэйгээр төгссөн бүх ард түмний санал хураалтыг бодсон ч гэсэн тэр миний бодлоор ойрын ирээдүйд төдийлөн ашиг тус авчрахгүй.

Иймээс би Италийн ерөнхийлөгч Наполитаногийн аравдугаар сард тавьсан сонирхолтой илтгэлдээ өнөөдөр юуг хийх шаардлагатай байна? Түүн дээр л анхаарлаа төвлөрүүлэе хэмээн шаардсантай санал нэг байна. Өнөөдөр хийх ёстой зүйлийг хийхийн тулд нэн ялангуяа төсвийн зохицуулалтыг бэхжүүлэх, ЕВРО-гийн хамрах хүрээнд эдийн засгийн ямар бодлого явуулах талаар өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй ЕХ-ны гэрээний бүх боломжийг шавхан ажиллах хэрэгтэй.

Лиссабоны гэрээний дагуу байгуулагдсан ЕХ-ны байгууллагуудын үйл ажиллагааны чадамжийн хямрал олон жилээр үргэлжлээд байж хэрхэвч таарахгүй!. Европын төв банкнаас бусад Европын парламент, Европын зөвлөл, Брюсселийн комисс, сайд нарын зөвлөл зэрэг байгууллагууд 2008 оны банкны хүнд хямрал нэн ялангуяа дараагаар нь залган үргэлжилсэн төрийн төсвийн хямралыг гэтлэн давахад чамлалттай бага хувь нэмрийг оруулсан.

Өдгөө нүүрлээд байгаа ЕХ-ны удирдлагын хямралыг гэтлэн давахад ямар нэгэн патентлагдсан жор байхгүй. Уг хямралыг гэтлэхийн тулд заримыг нь нэгэн зэрэг, заримыг нь дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх олон алхмуудыг хийх шаардлагатай. Бидэнд зөвхөн үнэлгээ дүгнэлт өгөх, эрчимтэй үйл ажиллагаа явуулах чадавхиас гадна тэвчээр

хэрэгтэй!. Үүний тулд германы оруулах концепцын шинжтэй хувь нэмэр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гардаг мэдээ төдийгөөр хязгаарлагдах учиргүй. Германы хувь нэмэр зөвхөн телевизийн зах зээл дээр бус харин ЕХ-ны сонгуульт байгууллагуудын итгэмжлэгдсэн хүрээнд танилцуулагдах учиртай. Ингэхдээ германчууд бид эдийн засгийн болон нийгмийн байгууллаа, бүгд найрамдах улсын бүтцээ, төсвийн болон санхүүгийн ерөнхий зарчмуудаа Европын түншүүддээ үлгэр жишээ эсхүл масштаб болгох байдлаар бус харин олон төрлийн боломжуудын нэг нь юм шүү гэдэг байдлаар танилцуулах нь зүйтэй.

Герман орны өнөөдөр хийж байгаа эсхүл хийлгүй орхигдуулсан бүхний Европын ирээдүйд үзүүлэх нөлөөний өмнө бид бүгдээрээ хариуцлага хүлээх болно. Үүний төлөө бидэнд Европ ухаан хэрэгтэй. Бид зөвхөн ухаалаг байх нь хангалтгүй, харин хөршүүд, түншүүдийнхээ зовлон жаргалыг өөрийн мэт хуваалцах, мэдрэх сэтгэл зүрх хэрэгтэй.

Зөвхөн цөөхөн хэдэн зүйл дээр би Юүрген Хавармастай санал нийлж байна. Заримаас нь би ишлэл татъя: ...ЕХ-ны түүхэнд бид анх удаагаа ардчилал бодитойгоор хумигдахыг харлаа!! (Ишлэл төгслөө.) Бодит байдал дээр: Европын зөвлөл түүний ерөнхийлөгч төдийгүй, Европын комисс түүний ерөнхийлөгч нэгэн адил, олон талт бүтэцтэй сайд нарын зөвлөл, Брюсселийн хүнд суртал бүхэлдээ ардчилсан зарчмыг шахан түрж байна!. Европын парламентыг ард түмэн сонгож байх тэр үед би парламент өөрөө зохих орон зайгаа эзлэх болно гэдэг төөрөгдөлд орчихоод байсан юм. Бодит байдал дээр Европын парламент өнөөгийн хямралыг даван туулахад

бодитой нөлөө үзүүлж чадсангүй, парламентаас гаргасан зөвлөгөө, шийдвэр олон нийтэд нөлөөлж чадсангүй.

Иймээс би Мартин Шүльцэд хандан: та болон танай Христосын ардчилагчид, таны социалист, либерал болон ногоонтны хамтран зүтгэгчдийн хувьд олон нийтийг дагуулах хамгийн оновчтой цаг үе нь ирээд байна хэмээн уриалж байна. Банк, биржүүдийн хяналтын зөвлөл, тэдгээрийн санхүүгийн хэрэгслүүдийн асуудал нь 2008 онд чуулсан ИХ наймын уулзалтаас хойш туйлын хангалтгүй ажилласан, орхигдсон тул энэ нь Европын парламентын хувьд олон нийтийн анхаарлыг татах хамгийн зохистой талбар нь байж болох юм.

Бодит байдал дээр АНУ, Европын хэдэн мянган санхүүгийн худалдаачид тэдэн дээр зарим рейтингийн агентлагууд нэмэгдээд Европын улс төрийн хариуцлагыг хүлээж буй засгийн газруудыг барьцаалж байна. Барак Обамаг үүний эсрэг чиглэсэн дорвитой арга хэмжээ авна гэж хүлээгээд хэрэггүй л болов уу. Британийн засгийн газраас ч хүлээгээд нэмэргүй л болов уу. Бодит байдал дээр 2008/2009 онд дэлхийн бүх засгийн газрууд баталгаа гаргаж татвар төлөгчдийн мөнгөөр банкуудыг аварсан. Гэтэл 2010 оноос хойш эдгээр оюунлаг хэрнээ сэтгэл мэдрэлийн өвчинд өртөмхий санхүүгийн менежерүүдийн сүрэг ашиг хонжоо олох бонус авах зорилгоор хуучин тоглоомоо дахиад л тоглож эхэлсэн. Энэ бол тоглоом нь оролцоогүй бусдыг хохироодог аз сорьсон тоглоом бөгөөд аль дээр 1990-ээд онд Марион Доенхоф бид хоёр амь насанд аюултай тоглоом хэмээн шүүмжилж байсан юм.

Хэрэв өөр хэн ч хуруугаа хөдөлгөхийг хүсэхгүй байгаа бол ЕВРО-мөнгөн тэмдэгтийн оролцогчид хөдөлж эхлэх ёстой. Яаж гэдгийг өнөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа Европын Холбооны гэрээний 20-р зүйлд заагаад өгчихсөн байгаа. Гэрээнд Европын Холбооны нэг буюу хэд хэдэн гишүүн орнууд хамтраад... илүү гүнзгийрүүлсэн хамтын ажиллагааг эхлүүлж болно.” гэж заасан байгаа. Ямар ч тохиолдолд Евро-мөнгөн тэмдэгтийг ашигладаг орнууд хамтран Евро-гийн орон зайд санхүүгийн зах зээлийн нэгдсэн зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгтэй. Ердийн арилжааны банкуудыг нөгөө талаас хөрөнгө оруулалтын болон сүүдрийн банкуудаас тусгаарлах, үнэт цаасны хоосон буюу хуурамч худалдан авалт хийхийг ирээдүйн тодорхой хугацааг хүртэл хориглох, биржүүдийн хяналтын албан ёсны зөвшөөрөл олгогдоогүй нөхцөлд худалдах, худалдан авалт хийх эрхийн тухай гэрээний худалдааг хориглохоос авахуулаад ЕВРО-гийн орон зайд түр зуурын, хяналтаас гадуур рейтингийн агентлагуудын эрхэлж буй арилжааг хязгаарлах хүртэл арга хэмжээ авах өргөн боломж байна. Ингээд би олон зүйлийг нуршиж хатагтай ноёд та бүхнийг чилээхээ больё.

Мэдээжийн хэрэг даян дэлхийг сүлжин хэрсэн банкны лобби бүлгүүд үүний эсрэг боломжтой бүх хөшүүргүүдийг хөдөлгөөнд оруулах болно. Эдгээр бүлэглэлүүд энэ хооронд нэгдсэн зохицуулалтуудыг нэвтрүүлэх бүх арга хэмжээнд тээг саад болсоор ирсэн. Тэд нар л тэдний худалдаачдын сүрэг Европын засгийн газруудыг дахин дахин “шинэ” авралын шүхрийг нээж олохоос өөр аргагүй байдалд албадан оруулж “хөшүүргээ” шүхрийг улам тэлэхэд ашигласаар ирсэн. Эдний эсрэг хамгаалалтын арга хэмжээ авах цаг нь болсон.

Хэрэв Европчууд бид санхүүгийн зах зээлийн нэгдсэн зохицуулалтыг нэвтрүүлэхэд зориг хүчээ нэгтгэж чадах юм бол дунд хугацааны дараагаар тогтвортой бүс болох боломж бий. Хэрэв бид энэ зорилгын дор нэгдэж чадахгүй юм бол Европын эзлэх жин хойшид ч буурсаар байх болно. Мөн дэлхий Вашингтон, Бээжингийн хоорондох Думын виратуудын чиглэлд хөгжсөөр байх болно.

Еврогийн орон зайд ойрын ирээдүйд хийнэ гэж яригдсаар байгаа, хийвэл зохилтой алхмуудыг хийх шаардлагатай. Эдгээрт авралын сангууд, өрийн дээд хязгаарыг тогтоох, тэдгээрт хяналт тавих, хамтарсан эдийн засаг болон төсвийн санхүүгийн бодлого хэрэгжүүлэх, дээрээс нь улс үндэсний дотоодын татварын бодлогын, нийгмийн бодлогын, хөдөлмөрийн зах зээлийн бодлогын шинэчлэлүүд хамаарна. Үүнийг дагалдаад нэгдсэн өрийн асуудал зайлшгүй босож ирнэ. Германчууд бид улс үндэстний хувьд хувиа хичээсэн аминч үзэл гаргаж үүнээс зайлсхийж таарахгүй.

Бид мөн Европ даяар мөнгөний эргэлтийг бууруулах хатуу бодлогыг сурталчилж хэрхэвч таарахгүй. Жак Делор төсвийг эрүүлжүүлэх бодлоготой зэрэгцүүлэн өсөлтийг дэмжсэн төслүүдийг эхлүүлж санхүүжүүлэхийг шаардсан нь зүйд нийцнэ. Өсөлтгүйгээр, ажлын байруудыг шинээр бий болгохгүйгээр аль ч улс төсвөө эрүүлжүүлж чадахгүй. Европ зөвхөн төсвийн хэмнэлт хийх замаар эрүүлжинэ гэдэгт итгэгч хүн бүр Хайнрих Брюнингсийн 1930/32 онуудад хэрэгжүүлсэн мөнгөний эргэлтийг бууруулах бодлогын үр дагаврын түүхийг уншиж судлах хэрэгтэй. Энэ бодлогын

үрээр эдийн засгийн уналт, урьд хожид үзэгдээгүй хэмжээгээр ажилгүйдэл бий болж ингэснээр Германы анхны ардчиллыг сүйрэлд хүргэсэн юм.

Найз нөхөддөө хандаж хэлэх үг

Эцэст нь хайрт найзууд аа, Социалдемократуудыг олон улсынэвсанаанынэгдэлдуриаландуудаадбайхшаардлага уул нь бол байхгүй. Учир нь Германы социалдемократууд хагас мянганы туршид олон улсын түвшинд найрсаг үйл ажиллагаа явуулж либералчууд, консервативчууд эсхүл Германы үндсэрхэг үзэлтнүүдээс үеийн үедээ илүү байсаар ирсэн. Социалдемократууд бид хүн бүрийн эрх чөлөө, алдар хүндийн төлөө тууштай тэмцсээр ирсэн. Бид төлөөллийн, парламентын ардчиллыг хамгаалсаар ирсэн. Эдгээр үнэт зүйлс маань бидэнд Европтой эв санааны нэгдэлтэй байх үүргийг ногдуулж байна.

21-р зуунд Европ тив өөрийн хэл, өөрийн түүхтэй улс үндэстнүүдийн тив хэвээрээ байх нь ойлгомжтой. Ийм ч учраас Европ тив Холбооны улс болчихгүй. Гэхдээ Европын Холбоо зүгээр л улс үндэстнүүдийн холбоо төдий болтлоо доройтох ёсгүй. Европын холбоо эрчимтэй хөгжилтэй холбоо хэвээрээ байх ёстой. Үүнтэй ижил төстэй түүх бүхэл хүн төрөлхтний түүхэнд байхгүй. Социалдемократууд бид энэхүү холбооны алхам алхмаар урагшлах хөгжилд хувь нэмрээ оруулах ёстой.

Хүн насаа ахихын хэрээр улам их урт цаг хугацааны орон зайд санаа бодол нь хөвөрч байдаг. Өтөл настай хүний хувьд

Годесбергийн хөтөлбөрийн гурван үнэт зүйлсийг би насан туршдаа дагаж мөрдсөөр ирсэн: Эрх чөлөө, Шударга ёс, Эв нэгдэл. Ингэхдээ өдгөө би шударга ёсны зарчим юуны өмнө хүүхдүүдэд, сургуулийн сурагчдад, залуу хүмүүст бүгдээрэнд нь тэгш боломж олгохыг шаардаж байна гэж боддог.

Би 1945 оныг санаж байна. Би мөн 1933 оныг ч санаж чадна. Тэр үед 14 настай байлаа. Тэр үед өнөөгийн бидний хүрээд байгаа хөгжил дэвшлийг төсөөлөх ч боломжгүй байлаа. 1948 оны Маршалын төлөвлөгөө, 1950 оны Шүманны төлөвлөгөө, Лех Балеса ба Солидарность, 77 оны Васлав Хавель, Харта нар, Лайпциг, Зүүн Берлинд оршин сууж байсан германчуудын ачаар 1989/91 онд болсон их эргэлтийн ачаар бид өнөөгийн хөгжил дэвшилд хүрсэн.

Өнөөдөр Европын дийлэнх хэсэгт хүний эрх, энх тайвны төлөө баярлаж байгаа энэхүү баярт үйл явдлыг бид 1918 он, 1933, 1945 онд төсөөлөх ч боломжгүй байлаа. Хүн төрөлхтний түүхэнд анхдагч болох Европын Холбоог өнөөгийн сул талуудаа туйлбартайгаар, өөртөө итгэлтэйгээр даван туулахад нь туслахын төлөө ажиллаж тэмцэцгээе.

ГСДН
2011 оны 12-р сарын 4, Берлин хот
Хэвлэл, мэдээллийнхэнд зориулан бэлтгэв.

ИЛТГЭЛ

ГСДН-ын Бундестаг дахь бүлгийн дарга
Франк-Вальтер Штайнмайерын ГСДН-ын
ээлжит их хурал дээр хэлсэн үг

Хэвлэлд бэлтгэсэн: Андреа Наалес
Редактор: Товиас Дюноү
Германы Социалдемократ Нам
Вильгелмын гудамж 141, 10963 Берлин хот
Утас: /030/25991-300, Факс: /030/25991-507
E-mail: pressestelle@spd.de, Internet:www.spd.de

Та бүхэн бүгд мэдэрч байгаа: Энэ бол өнгөцхөн харахад олон зочид, төлөөлөгчидтэй, олон үүрэг даалгавартай, олон илтгэлтэй, хурал бүрийн өмнөх сэтгэл догдлуулсан өдрүүдтэй ердийн л нэг намын ээлжит их хурал шиг харагдаж байгаа, гэхдээ нягтлан харвал урьдынхаас онцлогтой гэдгийг мэдэрч байгаа.

Харин бодит байдал дээр манай намын их хурал хуралдаж буй энэ цаг үе ердийнхөөс эрс өөр онцлог цаг үе тохиож байна. Хүн бүрийн аманд Еврогийн аврал гэдэг үг уяастай. Хэлмут Шмидт өнөө өглөө бидэнд “Еврогийн авралын цаана мөнгө, хангалуун амьдралаас илүү чухал зүйл яригдаж байна. Хагас зуун жилийн туршид бүрэлдэн тогтсон европын нэгдэл өнөөдөр цаашид ях нь бүрхэг болчихоод байна.” гэдгийг хэллээ.

Өнөөдөр нэгдэл маань задрал болчихоод байгааг бид харж байна. Энэ үйл явдал 1989 он шиг олон үр дагаврыг авчирч болзошгүй. 1989 онд хүйтэн дайн төгсгөл болж зүүний блок нуран унасан. Энэ задрал бол 1989 оныхоос тэс өөр чимээ багатай, сэмхэн гэтсэн, гэхдээ илүү аюултай байдлаар өрнөнө.

Энэ бүхнээс хоржоонтой нь юу бэ? гэхлээр: Герман улсад, бидний өдөр тутмын амьдралд энэ бүхэн бараг мэдрэгдэхгүй байна. Ханновер, Штутгарт, Шверин хотын иргэд хүүхдээ цэцэрлэг, сургуульд нь хүргэж өгөөд л. Ажилдаа явцгаагаад л. Амьдрал хэвшил болсон гольдролоороо хөвөрсөөр л байна. Үзэл бодол нэгт намын нөхөд минь, харин бид юуг мэдэрч байна бэ? гэвэл: Энэ хооронд манай улсад ч ялгаагүй

газрын хөрсөн дээр ямар нэг юм пор пор буцлаад байгааг бид мэдэрч эхлээд байна. Хүмүүс бие биенээсээ: Миний ажлын байр хэр найдвартай бэ? Евро мөнгөн тэмдэгт хэр тогтвортой бэ? Нэгдсэн европ бидний ирээдүй мөн үү? хэмээн асууцгааж байна.

Энэ бүх асуултын цаана илүү зарчмын асуудал байгаа юм. Дэлхий ертөнцийн энүүхэн хэсэгт ардчиллын ирээдүй ямар байх юм бэ? Хомхой сэтгэл, ашиг хонжоо харсан байдлыг сөрөн зогсох хэмжээнд ардчилал маань бэхэжсэн үү? Ардчилал хангалуун амьдрал, ажлын байрны баталгаа болж чадах уу?

Үзэл бодол нэгт эрхэм нөхөд өө, Энэ бүх асуултад хар-шарын эвсэл болох засгийн газар ямар ч хариулт өгөхгүй байна.

Тэд хүмүүсийн эдгээр асуулт болон эргэлзээнд ямар ч хариулт өгөхгүйгээр өөрсдөө учраа ол гээд орхиж байна. Хатагтай Меркель хямралыг тодорхойлох, хямралыг гэтлэх талаар хэлэх үгээ ч олохгүй сууж байна. Харин үүний оронд бидэнд хамгийн сайхан сэтгэлээр хандаж ирсэн хөршүүдийг маань хүртэл бидний эсрэг чиглүүлж хоёр нүүр гарган мэдэмхийрч байна. Бусдаас хэмнэлт хий гэж шаарддаг хэмнэлтийн сургагч багш байхыг хүсэж байгаа юм бол эхлээд өөрийнхөө гэрт хэмнэлтийн горимыг тогтоох хэрэгтэй.

Өөрийнхөө оршин байгаа хэсгээс бусад дэлхийн үлдсэн бүх хэсгийг болохоор хэмнэ, өрөө бууруул гэж шаардчихаад өөрийнхөө улсад шинэ шинэ өр нэмж тавиад байж хэрхэвч таарахгүй. Энэ талаар Европ тив бүхэлдээ ярьцгааж эрхэм

журмын нөхөд минь биднийг хоёр нүүртэн гэж нэрлэцгээж байна.

Бидний найз нөхөд, хөрш орнуудын юу хэлэлцэхийг бид сонсож байна. Тэд социалдемократууд бидэнд хандаж асуулт, шаардлагыг хүргүүлж байна. Хүмүүс Европт, хүчтэй, гэхдээ Европын Герман хэрэгтэй гэж хэлж байна. Итгэл нь суларсан Европт итгэл найдварыг эргүүлэн авчирч зүг чигийг зааж чадах улс төрийн хүчин Германд хэрэгтэй байна. Бидний европын хөршүүд бидэнд: “Энэ бол Социалдемократууд та бүхний үүрэг, бид та нарт найдаж байгаа шүү.” гэдэг шаардлагыг олонтаа тавьсаар байна.

Тийм ч ураас журмын нөхөд минь. Энэ их хурлаас Франц, Польш, Испани, Грек болон европын өнцөг булан бүрт суугаа журмын нөхөдөө хандан тодорхой уриаг хүргэмээр байна. Энэ уриалга нь: “Германы социалдемократуудад найдаж болно. Манай нам бол Европын төлөөх Германы нам” гэдэг үгтэй байгаасай гэж би хүсэж байна.

Францын Франсиос Холланде, Австрийн Вернер Фейман, Люксембургийн Жан Асселборн, энэ зааланд хүрэлцэн ирсэн Бохуслав Советка, бусад нөхдийг маань төлөөлөн хүрэлцэн ирсэн та бүхэндээ хандаж хэлэхэд: Европ тив консервативчууд, зах зээлчид, мэргэжилтнүүдийн тив биш. Европ тив бол хамтын ирээдүйдээ итгэдэг, айдас, үзэн ядалтаас ангид хүмүүсийн тив. Бид та бүхэнтэйгээ нэгдсэн Европыг, эв санааны нэгдэлтэй европыг хамтдаа байгуулахыг хүсэж байна. Энэ бол бидэнд бүгдэд нь ногдсон том үүрэг. Үүний төлөө хамтран ажиллацгаая.

Хайрт Мартин Шүлц, Чи Европын хувь заяа шийдэгдэх энэ чухал цаг үед Европын Парламентын Ерөнхийлөгчийн албыг хүлээн авлаа. Хэн ч байлаа гэсэн энэ бол хялбар алба биш. Гэхдээ энэ зааланд хуран цугларсан бид бүгдээрээ: Чи бол европын хамгийн сайн өмгөөлөгч, үүгээр ч зогсохгүй нийгмийн баримжаат Европын өмгөөлөгч. Юуны өмнө чи удахгүй Европын нийт социалдемократуудын нүүр царай болох болно. Би чамд хэлье: Бид хэзээд чиний найдвартай ар тал байх болно. Европын тайзан дээр чи бидэнд хэрэгтэй. Үүнээс хэцүү үе тулгарсан ч бид чиний ард ГСДН байх болно.

Хайрт найзууд минь, "Өөрөө бий болдог зүйл гэж үгүй. Урт удаан хугацаанд өөрчлөгддөггүй хэвээрээ байдаг зүйл гэж бараг байдаггүй."- Вилли Брандтын хэлсэн энэ алдарт өгүүлбэрийг та бүхэн бүгд мэднэ. Түүхэн тэр цаг үед тэрбээр эрх чөлөө, ардчиллыг ингэж тодорхойлсон юм. "Та бүхэн эрх чөлөө, ардчиллыг тэмцэж олсон бол түүнийгээ үүрд баталгаатай болсон гэж бүү тооц. Үеийн үед амьдруулж, хамгаалж байх ёстой." гэсэн санаа юм. Вилли Брандт бидний энэ үед амьдарч байсан бол нэгдсэн европын талаар энэ л үгээ давтан хэлэх байсан гэдэгт би итгэлтэй байна. Өдгөө тэр амьд сэрүүн байсан бол: "Зөвхөн улс үндэстнээ гэх богинохон бодол, амин хувиа хичээх үзэл дахин хүчирхэгжвэл европын нэгдэл үгүй болно." гэж хэлэх байсан. Өнөө тэр бидний дунд байсансан бол энэ заалыг тойруулж нэг харчихаад намуухан дуугаараа: "Европтой та нар болгоомжтой харьц." гэж хэлэх байсан. Эрхэм журмын нөхөд минь, чухам үүнийг бид хийх ёстой, энэ ээлжит их хурлын үеэр бид хоорондоо энэ талаар ярилцах ёстой.

Олон хүмүүс Европт шинэ дурсамж хэрэгтэй гэж ярьдаг боллоо. Энэ бол үнээн. Гэхдээ энэ чинь юу гэсэн үг бэ? Хуучин дурсамж үеэ өнгөрөөчихсөн гэсэн үг үү? Хэрэггүй болчихсон гэсэн үг үү? Бидний ой санамж үнэхээр ийм богинохон гэж үү? Миний бодлоор бид заримдаа телевиз үзэгчид шиг аашилдаг, "Тифанигийн өглөөний цай"-ны рекламн 72 дахь удаагийн давталт гарахад "яршигтай юм" гээд сувгаа сольдог шиг. Гэхдээ бид чинь телевизийн үзэгчид биш, түүх бол телевизийн реклам биш учраас бид уйтгартай байна гээд зүгээр л сольчихож болохгүй биз дээ?. Европ бол бидний түүх. Энэ түүх цаашид яаж үргэлжлэх бэ? гэдгийг өөр хэн нэгэн биш, бид өөрсдөө л шийдэх ёстой.

Харин түүх бидэнд өнөөдөр юуг өгүүлнэ бэ? Хүн бүрийн сэтгэлд өөр өөрөөр хоногшсон байдаг. Пеер нас барагчдад зориулан сүмд босгосон дурсгалын самбар түүнд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн талаар ярьдаг. Харин европын түүх миний ой тойнд өөрөөр хоногшсон байдаг бөгөөд би үүнийг байнга эргэн дурсдаг. Нэг удаа би Жан Клоуд Жанкертэй европын хямралын талаар эцэс төгсгөлгүй яриа өрнүүлж удаан суусан юм. Шөнө дундаас цааш явахаа байж байнга гай болж байдаг хөршүүддээ уурссан уур буцалж "Нэгдсэн европ ер нь хэнд хэрэгтэй юм бэ? гэж асуудгийн алдад "Жан бүр өөрт нь хамаагүй юм ярьж байгаа юм шиг өнгөөр "Франк аа, хэн нэгэн чамаас европын үндэс, эсхүл утга учрын талаар асуух юм бол чи тэр хүний гараас хөтлөөд европын цэргүүдийн оршуулгын газраар хагас цаг хэртэй хамтдаа алх" гэж хэлсэн нь надад таалагдсан юм. Би түүний хэлсэн ёсоор тус оршуулгын газарт очиж хагас цаг хэртэй алхсан юм. Эрхэм журмын нөхөд минь, би ганцхан удаа ч биш хэд хэдэн

удаа түүний хэлсэн ёсоор алхсан. Тэнд өч төчнөөн мянган загалмай шигтгэсэн оршуулга байдаг. Тэд бидэнд: “Түүхийг сануулдаг юм.” Европ бол үүний хариулт. Хэлмут Шмидт өнөөдөр бидэнд өнөөдөр “Хэдэн зууны туршид дайн, иргэний дайн европт үргэлжилж зөвхөн дэлхийн хоёрдугаар дайнд гэхэд 60 гаруй сая хүн амь үрэгдсэн.” гэдгийг сануулсан. Энэ бүх хар барааныг туулсны дараагаар “Дахин хэзээ ч бүү дайт” гэдэг уриа бол бидний ухаарал байлаа. Бидний улс төрийн өвөг дээдэс Европын ямар суурин дээр боссон билээ? гэдгийг мэддэг байсан юм. Тэд л тамлан зовоолт, буудан хороолтын золиос, нас барагсдын сая сая булшин дээгүүр эцэст нь бие биедээ гар сунгасан юм.

Та бүхэн магадгүй “Бид мэднэ, бид нэг удаа тэр талаар сонсож байсан юм байна” гэж хэлж магадгүй. Би тэгвэл та бүхэнд “Тийм ч байж магадгүй л юм. Мэддэг ч байж болох юм. Гэхдээ түүх дуусаагүй байна” гэж хэлэх байна. Учир нь миний та бүхэнд ярьж байгаа зүйл бол түүхийн хуудаснаас уншиж буй зүйл биш, цагаа өнгөрөөсөн тэр тусмаа хуучин дурсамж биш. Үгүй ээ. Эрхэм журмын нөхөд минь. Энэ бол одоо бидний дээр нь зогсож байгаа фундамент гэдгийг мэдрэх ёстой. Би чухам өнөөдөр өөрсдөө дээр нь зогсож буй фундаментын тухай ярьж байна. Яагаад гэхээр бид энд ямар үнэт зүйлс үгүй болох гэж байна? Тэдгээрийг бид өнөөдөр хэрхэн хамгаалах бэ? гэдэг талаараа ярих ёстой. Үүнийг бид ухамсарлах ёстой юм шүү, журмын нөхөд минь.

Өнөөдөр Хэлмут Шмидтийг үгээ хэлж байхад, өнөөдөр тавин таваас дээш насныхан буюу миний үеийнхэн “ Бид дайны дараах үеийн хүүхдүүд” гэж байнга хэлдэг үгнийхээ утгыг

ухаарлаа. Энэ юу гэсэн үг болохыг та нар мэдэх үү? Бид бол бүх л амьдралынхаа туршид энх тайван байдалд амьдарсан, дайн үзээгүй европ тивийн анхны үе удам.

Би европын улсууд Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэгийн гэрээнд нэгдэхийн өмнөх жилд мэндэлсэн. Би бага залуу байхдаа хилийн шонгуудыг хэрхэн буулгахыг, улс орнуудын хил улам бүр нээлттэй болж байгааг харсан. Би болон миний үе тэнгийнхэн хэдийгээр тухайн үед эгэл гэж хэлж болохоор хангалуун амьдрал европтой хамт, европ тивд дайн дууссанаас хойш арван жилийн дараагаас аажим аажмаар эргэн ирэхийг харж бид үүнээс хожсон юм. Миний үе тэнгийнхэн Хаарц, Хар ойн үзэсгэлэнт дундад уулс хэвээр үлдэж харин горизонт нь илүү өргөн уудам болохыг харцгаасан юм. Европ бүхэлдээ бидний тив болж нэн ялангуяа зуны амралтын үеэр бид хөндлөн гулд аялцгаадаг болсон юм. Муж улсад өссөн залуу хүүгийн хувьд, дараа нь их сургуульд Европ тив хэрхэн зүрх, тархиа нээхийг харж дээд сургуулиудын оюутан солилцооны хөтөлбөрийн хүрээнд илүү их орон зай миний нүдний өмнө нээгдсэн юм. Би Хоёр герман улс дахин нэгдэхийг харсан, энэ нэгдэл Европгүйгээр боломжгүй байсан, ингэснээр Польш, Чех, болон зүүн европын бусад орнуудын хилээр европ тивийн хил хязгаар тэлж дайн дууссанаас хойш бүхэл бүтэн 45 жил өнгөрсний дараа манай тив ийнхүү найрамдсан юм.

Энэ бүхнийг та нарт нуршсаны учир бол” Европ бол өдөр бүр биднийг хооллож ундаалж байдаг бурхны бэлэг. Европгүйгээр бидний амьдрал өнөөгийнхөөс өөр байх байсан, бид өнөөгийнх шиг аз жаргалтай байж чадахгүй

байсан. Үүнд би итгэлтэй байна. Энэ түүх бол үеэ өнгөрөөсөн эрт балар үеийн дурсамж биш. Харин ч эсрэгээрээ: Энэ дурсамж бол ГСДН-ын захиас бөгөөд үүрэг. Эрхэм журмын нөхөд минь, энэ бол бидний үүрэг. Эрх чөлөө, Ардчилалд заналхийлбэл, эдгээр үнэт зүйлс маань тэрэгний дугуйн дор гишгэгдэх аюул учирвал хамгаалах нь бидний үеийн үед хүлээсэн үүрэг юм шүү. Бууж өгч болохгүй.

Эрхэм журмын нөхөд минь, Чухам энэ бол европын социалдемократизмын үүрэг, тэр дундаа ГСДН-ын үүрэг юм.

Журмын нөхөд минь: Энэ хариуцлагыг бид ирээдүйд ч хүлээсээр байх болно!

Санхүүгийн хямралын үед энэ бүгдийг мартсан юм шиг царай гаргахаа больцгооё. Би та нарт “Харин ч бүр эсрэгээрээ Национализм чимээ аниргүй айсуй гэдгийг харуулж байна” гэдгийг хэлье. Би Утояд болсон балмад явдлын талаар яриагүй. Би Германд байгаа барууны алан хядагч терроризмын урсгалын талаар ярихгүй. Харин би европын хүн амын дунд байгаа сэтгэл ихээр зовоосон, муухай үндсэн урсгалуудын талаар ярьж байна. Та бүхэн европ тивийн хөрш орнуудад сүүлийн үед явагдсан сонгуулийн үр дүнг харцгаа. Газар сайгүй Европын парламентад шовинист (үндэсний дээрэнгүй үзэл), популист хүчнийхэн орж ирсээр байна. Та нар Голландын Геерт Вилдерсыг харцгаа. “Жинхэнэ финчүүд” –ийг санаж байгаа. Хар хувцсаар ижилсээд Будапештын гудмаар жагсаж байсан Унгарын Жоввик үндсэрхэг үзэлтнүүдийг санацгаа. Энэ бүхэн үнэхээр гутамшигтай. Үүнээс ч илүү миний сэтгэлийг зовоож байгаа

зүйл бол: Энэ бүхнийг нэгдсэн европын түвшинд асуудал болгон хэлэлцүүлэх хүч бидэнд дутагдаж байна. Бид тэднийг зоргоор нь орхиж асуудалд оролцохгүй байна.

Бид хангалттай хэмжээнд асуудалд оролцохгүй байна. Харин ардчилалд дарамт учирвал бид оролцох ёстой. Энэ талаар ярихдаа би бусдаас бурууг хайхгүй, зөвхөн хөршүүдээ яриад зогсохгүй. Бид өөрийнхөө орны нөхцөл байдлыг нарийн шинжлэн үзвээс европыг эсэргүүцсэн хошин өнгө аястай яриа гарах болсныг сонсож болно. Энэ өнгө аяс манай улсын улс төрийн хүрээнд хүртэл тархсан байна. Чөлөөт Ардчилсан Намынхан нам дотроо бий болоод байгаа үндэсний консерватив чиг хандлагыг ихээхэн хичээл зүтгэл гаргаж байж чадан ядан хяналтандаа байлгаж байна. Христосын Нийгмийн Ардчилсан Холбоо (ХНАХ) болон ноён Довриндт Европын эсрэг учир битүүлэг хорон үг шидэх, Өмнөд Европынхныг залхуу гэж шүүмжлэн гал дээр тос нэмэх олдсон боломж бүрийг алдалгүй ашиглаж байна. Өдгөө тэр ч байтугай ХНАХ-ынхан Каудер өөрийн Казино- хоолойгоор “Европт хүмүүс одоо германаар л ярьдаг болж” хэлэх бүрийг алдахгүй анаж суудаг болж. Чухам үүнийг л Хэлмут Шмидт өнөөдөр хэлсэн үгэндээ дурьдсан.

Ийм ч учраас бид европын хөршүүд маань бүгдээрээ Германы биеэ өргөмжлөх үзэл дахин сэргэж байгаа юм биш байгаа даа “хэмээн сэтгэл зовнин харж байвал үүнд гайхаад байхын хэрэггүй юм. Би уг нь хатагтай Меркелийн амнаас үүнээс зай барьсан, зэмлэсэн үг унах болов уу? гэж найдсан юм. Би харин: “Каудерын хэлсэн үг шиг замаасаа хазайсан зүйлийг зүгээр өнгөрөөгөөд байвал энэ засгийн газраас

гаргасан 1000 хол давсан ямар ч хэрэггүй тайлбар юунд хэрэгтэй юм бэ?.” гэж дотроо бодсон.

Би намаараа бахархаж байна. Би эдгээр бүх хүндрэлийг сөрөн зогсож байгаадаа , манай намд ийм өнгө аяс байхгүй гэдгээр бахархаж байна. Шовинизм, европын эсрэг чиглэсэн популизм алинд нь ч манай намд орон зай байхгүй. Энэ бол өнөөгийн цаг үед ойлгомжтой, байх ёстой хэвийн зүйл биш. Үндсэрхэг үзэл хааш нь хөтөлдөг бэ? гэдгийг үй түмэн зовлон гамшиг амсан байж мэддэг болсон түүхтэй маань холбоотой. Бид цаашид ч үндсэрхэг үзэл газар авахаас нэн ялангуяа өөрийнхөө оронд сэргийлж байх учиртай. Миний хувьд арван жилийн туршид барууны хэт радикал үзэлтнүүд улс орон даяар хэрэн хэсэж бидэнд хамаардаг хүмүүсийг алж байсныг ойлгоход бэрхтэй юм. Тэдний золиос болсон хүмүүс, тэдний ар гэрийнхний өмнө бид буруутай.

Энэ бараан намгийг хатааж чадаагүйн хариуцлагыг бид хүлээх ёстой.

Та нар харж байгаа: “Европын хуучин дурсамж үеэ өнгөрөөгөөгүй гэдгийг та нар харж байна. Энэ дурсамжийн өмнө бид цаашид ч хариуцлага хүлээсэн хэвээрээ байх болно. Энэ дурсамж бол үнэн бөгөөд итгэл үнэмшилтэй хэвээрээ байна. Миний охин болон надаас хойш мэндэлсэн хүмүүсийн тухайд бол миний бодлоор “Энэ түүх тэдэнд хангалтгүй. Ийм ч учраас бид бүрэн шинэчлэгдсэн дэлхий дээр Европын гүйцэтгэх үүргийн талаар нэгэн шинэ бүлгээр европын түүхийг баяжуулах ёстой. Гэхдээ энэ бол шинэ үүрэг биш. Олон жилийн өмнөөс бид энэ хариултыг хайсаар ирсэн. Бидэнд орж ирсэн санаа хэтэрхий бараан, шинэ дурсамжид

хэрэг болохооргүй зүйл байсан. Энэ бол бидэнд ногдож буй шинэ үүрэг. Харамсалтай нэлээд хэдэн өдрийн өмнөөс европын шинэ дурсамжийн төслийг бичихэд амаргүй нөхцөл үүсчихлээ. Та нар бүгдээрээ үүнийг ажигласан эсэхийг би мэдэхгүй: “Хэдхэн өдрийн өмнө Барак Обама ертөнцийн нөгөө буланд Австралийн нийслэл Канберра хотноо нэг илтгэл тавьсан. Энэ нь илтгэл гэхээсээ илүү зүг чигийг заасан утгатай зүйлийг хэлсэн. Бид энэ илтгэлийг хэдэн жилийн дараагаар түүхэн илтгэл гэж нэрлэх болно гэдэгт би итгэлтэй байна. Түүний хэлсэн үгийг Жон Кеннедигийн энд Берлин хотноо Шөнеберг дэх Хотын зөвлөлийн байшингийн өмнө хэлсэн үгтэй адилгаж болмоор. “Би Берлин хотын иргэн” гэдэг үгийг бид бүгдээрээ мэднэ. Энэ бол мартагдашгүй дөрвөн үгс. Гэхдээ олон арван жилийн туршид тогтвортой хадгалагдаж чадсан трансатлантын түншлэлийг хамгийн товчоор, хамгийн их сэтгэл хөдлөлөөр илэрхийлсэн үгс. Би “Барак Обамагийн хэдхэн хоногийн өмнө Австралийн парламент дээр хэлсэн үгсийг олон жилийн туршид мартагдахгүй” гэдэгт итгэлтэй байна. Та нар анхааралтай сонсож бай! Тэрбээр “АНУ бол номхон далайн гүрэн. Бид эндээ үлдэхийн тулд энд байна.” гэж хэлсэн юм. Эрхэм журмын нөхөд өө, намын ээлжит их хурал дээр та бүхнийхээ дунд” Энэ бол Америкийн ашиг сонирхлын өөрчлөлтийг нээлттэй илэрхийлсэн өгүүлбэр.” гэдгийг хэлье. Бид энэ өгүүлбэрийн төлөө хорсоод, сэтгэлээр унаад байхын хэрэггүй. Харин Обама энэ өгүүлбэрээр трансатлантын харьцаа өнөөг хүртэл явж ирсэн хэлбэрээрээ, өөрөөр хэлбэл АНУ-ын гадаад харилцаанд олноос онцгой байр суурь эзлэхээ больсон, хоцрогдсон гэдгийг илэрхийлсэн. Бид үүнийг “Европ АНУ-ын засгийн газрын албан ёсны хэлэнд ашиг сонирхлын төвд байх байр суурийг эзлэхээ байсан”

гэдгийг тодорхой хэлчихлээ гэж ойлгох ёстой.”

Үүнийг би яагаад хэлээд байна бэ? гэхлээр Энэ бол түүх ярьж байгаа хэрэг биш, харин би үүгээрээ “Хожимдоогүй дээрээ одоо нойрноосоо сэргэж үз. Европчууд бид урт хугацааны туршид, бүр хэтэрхий удаан бодит байдалд биш, бодит байдлын тусгалд амьдарч ирж. Өнгөрснөө санагалзаж өмнөх чухал байсан үеэ дурссаар. Харин бид ертөнцийн өөр хэсэгт, Азид, Латин Америкт юу болж байгааг үл тоомсорлож басамжилсаар иржээ. Бид чухал хэвээрээ ч гэлээ ач холбогдол багатай болсон байна.

Миний одоо хэлэх зүйл үүнтэй холбоотой учраас би” Хэрэв бид нөлөөтэй байхыг хүсэж байгаа бол жишээлбэл: цаг уурын өөрчлөлт, санхүүгийн зах зээл, худалдааны зохицуулалтанд нөлөөтэй байхыг хүсэж байгаа юм бол та бүхэн ирээдүйд европын 27 улсыг нэг нэгээр нь дуудаж саналыг нь асууна гэж бодож байна уу? энэ асуултын хариулт бол амархаан: Эсвэл бид нэгдсэн бодолтой байна, нэгдсэн бодолгүй бол бүгд доошоо унана, хэн ч хэрэгсэхгүй.

Дэлхий дээр шинэ дэглэм тогтсон энэ үед нэг зүйл тодорхой. 27 салангид бодол хэдхэн жилийн дараагаар дэлхий дахины хүчирхэг давлагаан дунд зүгээр л гээгдчихнэ. Үүнийг бид хүсэхгүй нь ойлгомжтой. Өөрсдийнхөө төлөө гэсэн сэтгэл үүнийг хийхийг зөвшөөрөхгүй учраас, бид зөвхөн өөрийнхөө оршин буй тивийн өмнө бус, дэлхий нийтийн өмнө хариуцлага хүлээдэг учраас хүсэхгүй. Би үргэлж “Энх тайван, шударга нийгмийн тухай европ мөрөөдөл бол зөвхөн европынхны мөрөөдөл биш, харин энэ дэлхийн олон хүмүүсийн мөрөөдөл” гэж хэлдэг.

Тэд биднийг мөрөөдлөө биелүүлээсэй гэж хүсэж байгаа. Энд Европ тивд бид бусдын өмнө үлгэр жишээг үзүүлэх ёстой. Энэ бол бидний үүрэг. Иймээс бид өнөөдөр уруу царайлж болохгүй, үүний төлөө бид цаашид ч тэмцэх учиртай. Чухам өмнөхөөсөө бэрхшээлтэй болсон энэ үед, чухам бид нар л тэмцэх учиртай.

Ингэхлээр нөхөд минь, Та нар одоо “Сайн байна. Чамайг дагая, тэгээд харъя, Бидэнд, Европ чухал гэдгийг мэдэж байна, маргаашийн дэлхийд европ чухал гэдгийг мэдэж байна гэж бодож байгаа. Миний бодлоор урьдын тусгаар үндэсний хуучин дэлхий рүү буцах зам байхгүй. Зарим нь” Европ шатаж байна гэж чи өөрөө бидэнд хэлсэн. “Одоо тэгээд яах бэ? гэж асуух байх. Энэ хямралаас бид яаж гарах юм бэ? Миний тэдэнд өгөх эхний хариулт бол” Ямар ч байсан хатагтай Меркел шиг биш” гэж би хариулна.

Би зөвхөн сөрөг хүчний удирдагч болохоороо ингэж хэлж байгаа юм биш. Эдний хуарангийнхны хоёр жилийн туршид яаж аяглаж аашилж байгаа нь үнэхээр миний дургүйг хүргээд байгаа учраас би ингэж хэлж байна.

Би асуудлын нарийн ширийн рүү орохыг хүсэхгүй байна. Энэ талаар үүнээс өөр газруудад олон удаа ярьсан. Би эд нарын холбиромтгой байдлын талаар ч ярьмааргүй байна. Брюссель хотод хэвлэл мэдээллийн дурангууд харахаараа европын нэг их чухал иргэн болчихдог, Брюсселиэс өөр газар камер, дуу хураагч байхгүй гэдгийг мэдчингүүтээ Саурландын хойморт оччихлоороо Өмнөд нутгийнхан залхуу гэж муу хэлээд суудаг байж таарахгүй биздээ? Үүнийг

л би холбиромтгой гэж хэлээд байгаа юм. Ингэж барих барьцгүй загнаж болохгүй биз дээ?

Би дандаа л эрх мэдэл-ямар ч үнээр хамаагүй засгийн эрхэнд гарах гэсэн эвслийн талаар яриад баймааргүй байна. Эрхэм журмын нөхөд минь, Европт хямрал эхэлснээс хойших сүүлийн 18 сарыг харцгаа. Өнөөдрийг хүртэл европын болон эдийн засагт шаардлагатай байгаа асуудлуудаас юу ч шийдэгдсэнгүй, улам доройтож байгаа ЧӨН-тай эвссэн эвслийн хүрээнд дөнгүүрхэн шийдэж болох зүйлсийг л шийдэж байна. Энэ чинь дэндүү бага байна нөхөд минь.

Сонгуулийн хугацааны тал хувь нь өнгөрсний дараагаар энэ засгийн газар ард түмэндээ ямар мессеж илгээв? гэдэг талаар би өмнө нь өөр газар ярьсан учраас дахин ярихгүй. Тэдний хийгээд байгааг бид өмнө нь өөр байран дээр хийж л байсан. Амлалт, улаан шугам, хэн ч ам алдаж болохгүй нууц, Меркелийн засгийн газар нэг жил гурван сар эрх барих хугацаанд юу юу ч хуримтлагдчихав? Эдний хэлээд амлаад байгаа зүйлд хүмүүс үндсэндээ эргэлздэг болоод байна. Би зөвхөн ганцхан түүх ярья. Олон түүх байгаа ч би ярихыг хүсэхгүй байна. Энэ үзсэн хүн ичиж улаймаар театрын жүжиг бол европын улс төрийн тайзан дээр үнэхээр тоглогдсон үнэн түүх.

Одоо, Европ бүхэлдээ хямралд гүнзгий шигдэхийн хэрээр Итали, Испани, Франц, бүгдээрээ нийлээд хямралтай тэмцэлдэж байхад хатагтай Меркель нэг шидэт томьёо бэлдчихээд сууж байж. Түүний шидэт томьёо нь: гэрээний өөрчлөлт. Гэрээний ирээдүйн талаар одооноос бодож

байгааг нь эсэргүүцээд байх юм бол надад алга. Ийм байдалд орсон хүн өөр яах ч билээ. Харин энэ гарчгийн дор сэтгэлгээний өөрчлөлтийг авчрах гэж оролдоод байгаа нь чухам энэ засгийн газар, төсвийн сахилгыг зөрчигсдөд автоматаар шийтгэл ногдуулах аргыг бодож олсон нь чухам энэ засгийн газар гэж яриад байгаа нь таалагдахгүй байгаа юм.

Журмын нөхөд минь, та нар үүнийг санаж байгаа эсэхийг би мэдэхгүй. Үнэн байдал бол шал өөр. Одоогоос нэг жил гаруйн өмнө, 2010 онд комиссын ерөнхийлөгч Бароссогийн өөрийн биеэр танилцуулсан нэгэн санал миний өмнөх ширээн дээр тавиаастай байсан. Тэр нь ямар санал байсан бэ? гэвэл одоо санахад: Мөнгө дутаасан нүгэлтнүүдэд автоматаар шийтгэл ногдуулна гээд биччихсэн байсан юм. Энэ шийтгэлийг Европын комисс нэвтрүүлэхийг хүссэн байлаа. Цаанаа ямар санаа агуулаад байгааг нь багцаалж болохоор байсан юм. Тэр үед хямрал дөнгөж хагас жилийн настай байсан үе. Тухайн үед энэ нь цагаа олсон журам болох байсан юм. Гэтэл энэ журмыг баталснаар европчуудын итгэлийг алдчихаж магадгүй гэж болгоомжилсон юм. Гэтэл та нар "Тэр үед нь Германы канцлер юу хийсэн гэж бодож байна? Нэг жилийн өмнө тэр өөрийн найз Бароссогийн арай гэж нэг юм Европт төсвийн сахилгыг тогтоох саналыг дэмжсэн үү? Тэгвэл хариулт нь: Үгүй. Тэр түүнийг дэмжээгүй, тэрнийхээ оронд Деаувиллигийн наран шарлагын газар очиж ерөнхийлөгч Саркозитай уулзсан юм. Үүнээс нэг цагийн дараа комиссыг тонгорчихоод саналыг гарынхаа араар ширээн дээрээсээ түлхэж унагаагаад дуусаа. Шууд автоматаар шийтгэл ногдуулдаг байхыг бид дэмжихгүй байна. Энэ бол зүгээр л

Деаувиллийн наранд шарлагын газар төрсөн мэргэн санаа байсан юм. Өнөөдөр, нэг жилийн дараа хамаг итгэл найдвар юу ч үгүй салхинд хийссэний дараагаар гэнэт эсрэгээрээ нөгөө санал нь зөв болж шийтгэл ногдуулахыг дэмжих болж байна. Үүнийг юу гэж ойлгох бэ? Энэ хүнд ер нь барих барьц байна уу? Өчигдөрхөн хүрэл хууль байсан зүйлийг өнөөдөр зүгээр л хаячихаж байна. Иймэрхүү зүйлийг өөрийгөө хүндэтгэх хүндэтгэл гэж үгүй болчихсон эвслийн хүрээнд хийж болдог л байх. Харин парламентын болон улс төрийн олон нийтийн өмнө ингэж болохгүй. Энэ чинь ардчиллын нэр төрийг гутааж байна.

Миний бодлоор энд тууштай байдал дутагдаж байна. Меркель бүтэн жил хагасын туршид өрийг нийгэмчлэхийн эсрэг байна гэж мөргөлийн хүрд шиг давтаж байсан. Ингэж хэлж болно. Харин илүү нухацтай харах юм бол Меркель Саокози хоёр өрийг нийгэмчлэх эрчлүүр дугуйг эргэлтэнд оруулсан эзэд нь. Европын орнуудын засгийн газрууд ээлж дараалан хямралд автагдаж хямрал улам гүнзгийрч эхлэхэд европт ганцхан актёр үйл ажиллагаагаа явуулж байсан нь Европын Төв Банк (ЕТБ). Өөр хэн байсан юм бэ? Ганцхан төв банк л өдрөөс өдөрт гал унтраагчийн үүргийг гүйцэтгэж байлаа. Магадгүй эрх зүйн хувьд нь авч үзвэл жаахан саарал бүсэд ажиллаж байсан байх. Комисс ч тэр, Европын зөвлөл, хэн ч гүүрэн дээр харагдахгүй байхад Европын төв банкинд өөр арга ч байгаагүй, миний бодлоор Валютын сангийн цөмийг хайлахаас ганцхан ЕТБ л сэргийлж байгаа. Ийм учраас зөв байсан юм. Журмын нөхөд минь.

Харин үүнээс ямар үр дагавар гарсан бэ? гэвэл: Тэд

балансандаа элбэг 200 тэрбум евротой байна. Энэ баланс нь удахгүй 300 тэрбумд хүрнэ. Би : “Энэ чинь юу болж байна? Бурхан өршөөг. Өрийг нийгэмчлэх гэсэн бүх зүйлд канцлер өдөр бүр саад хийгээд байгаа гээгүй бил үү? гэж асууж байна. Эдгээр өгүүлбэрээр германы олон нийтийг өдөр бүр хуурч суугаа юм биш үү? Ингээд байхад хэн , үгүй нээрээ хэн улс төрд итгэх юм бэ? Энэ бүхэн зөвхөн засгийн газарт төдийгүй улс төрд бүхэлд нь итгэх итгэлийг бууруулж байгаа нь хохиролтой юм. Журмын нөхөд минь.

Та нар сая сонслоо: Би бол илтгэл тавих хамгийн сүүлийн хүн. Европын Төв Банкны хямралын үед гүйцэтгэж буй үүргийн талаар ярилаа. Ингээд өргөдлийнхөө агуулга руу орёе. Бид энэ талаар хоорондоо хангалттай ярих ёстой. Энэ маш чухал. Бид ЕТБ-ны үүргийн талаар хоорондоо хангалттай ярих ёстой. Би намын бүлэг доторхи олон нөхдийнхөө энэ талаар баримталж буй байр суурийг мэднэ. Энэ зааланд нэлээд хэд нь сууж байгаа гэж би бодож байна. Тэд: Бид ЕТБ-нд эрх мэдэл өгөх хэрэгтэй. Бусад тэмдэгтийн банкуудыг төв банкнаас гадуур байгуулах хэрэгтэй гэж хэлнэ. Ний нуугүй хэлэхэд ЕТБ-ны өнгөрсөн 1,5 жилийн хугацаанд аргагүй байдалд орсны улмаас үзүүлсэн туслалцааг Европын санхүүгийн бодлогын хаан зам болгох хэрэгтэй эсэхэд эргэлзэж байна. Бүх хүмүүс бүгдээрээ: Хуучны ЕТБ-ыг орчин үеийн тэмдэгтийн банк болгож шинэчил, Холбооны нөөцийн банк болго гэж хэлнэ. Тэгвэл би тэдэнд хандаж: Та нар итгэл үнэмшилтэй зөвлөгөө өгөхөөсөө өмнө эхлээд ялгааг нь нэг сайн харчих гэж хэлэх байна.

Америкийн холбооны нөөцийн банк, Швейцарын,

Британийн тэмдэгтийн банкууд тэд бүгдээрээ мөнгөн тэмдэгтийн хомоген буюу нэг төрлийн валютын бүсийг хариуцдаг. ЕТБ бол Валютын сангийн 17 гишүүний төв банк. Бүгдээрээ бие даасан, бүгдээрээ өөрийн засгийн газартай, бүгдээрээ өөрийн парламенттай, юуны өмнө мөнгөний бодлогодоо хоорондоо эрс зөрүүтэй өөрийн гэсэн онцлог эмзэг байдалтай.

Ийм учраас би бусад орнуудын загварыг Европ руу хуулбарлах нь зарим хүмүүсийн төсөөлж байгаатай адилхан тийм амархан бүтэх үү? гэдэгт эргэлзэж байна. Би энэ эргэлзээнийхээ талаар ярихдаа АНУ-ын Холбооны нөөцийн бодлого урт хугацаанд амжилт авчрах уу? гэдэгт эргэлзэж байгаа тухайгаа огт яриагүй байна. Би үүнийг өөрөөр илүү тодорхой хэлж болно. Өдгөө европчууд бид европын санхүүгийн бодлогын хувьд шаварт суучихаад байгаа нь АНУ өрийн хязгаарыг анхаарлынхаа гадна орхисон ч ажил нь бүтээд байгаа гэсэн үг биш. Тэнд гамшиг зөвхөн нууц байдалд байгаа юм биш биз гэж би айж байна. Энд тохиолдоод байгаа зүйлс тэнд ч мөн тохиолдох бий гэдгээс айж байна.

Үгний далимд хэлэхэд: Ам нээвэл уушиг нээ гэдэгчлэн улс төрийн хувьд ингэтлээ их цэнэгжсэн ЕТБ-ыг бие даалгачихвал ардчилал юу болох бэ? гэдгийг бодох хэрэгтэй. Нарийвчлан харвал ЕТБ одоо ч европын эдийн засгийн албан бус засгийн газрын үүргийг ерөнхийдөө гүйцэтгэж байна. Тэнд банкны мэргэжилтнүүд төрийн зээлийг худалдаж авах уу? үгүй юу? гэдгийг шийдэж ингэснээр засгийн газруудын хувь заяаг шийдэж байна. Хямралын тэг дунд, өрийг нийгэмчлэх асуудлыг тойрон гарах ямар ч боломжгүй болох үед ЕТБ

руу зам хөтөлж, тэнд ямар ч ардчилалгүй, ямар ч олон нийтийн хяналтгүйгээр асуудал шийдэгдэнэ. Ийм жишээг бид мэднэ. Зүгээр л нэг хөнгөн хийсвэр зөвлөгөө өгөхийн оронд үүнийг бид ухааныхаа мухарт санаж байх хэрэгтэй. Ардчилал, ардчилсан хяналт илүүц биш нь лавтай. Үүнийг бид ухамсарлах учиртай.

Харин миний бодлоор: Миний хэлсэн бүх нотолгоотой маргаж болно. Гэхдээ наанаа ЕТБ-ны бодлогыг эсэргүүцээд байгаа царай гаргасан хэрнээ цаанаа болохоор цаашид үргэлжлээсэй билээ хэмээн залбирч суудаг Холбооны Засгийн газрын бодлоготой л эвлэрч болохгүй. Би үүнийг дандаа хэлдэг: Өдрийн цагаар болохоор Ангела Меркель ЕТБ-ны бодлого, түүний явуулж буй мөнгөний бодлогод би маш шүүмжлэлтэй хандаж байна гэж хэлдэг. Харин үдшийн бүрэнхий эхэлмэгц ЕТБ одоо явуулж буй бодлогоо цаашид үргэлжлүүлээсэй гэж залбирдаг. ЕТБ-ны үйл ажиллагаа зогсчихвол энэ засгийн газар чадамж нь хүрэхгүй байгаа шийдвэрийг гаргах хэрэгтэй болно. Энэ бол үнэн шүү журмын нөхөд минь.

Европ салаа замын уулзвар дээр ирээд байна. Гэхдээ энэ салаа замын уулзвар дээр хүмүүс анх удаа ирээд байгаа юм биш. Өмнө нь ч ирж л байсан. Өмнө нь зөвхөн хямралаар зогсохгүй, цус урсгасан иргэний дайны ард гарсан улсуудын бүлэг ч ирж л байсан. Дайнд ялсан ч итгэл найдварын оч ч үгүй болтлоо өрөнд орчихсон улсууд үгүйрэл хоосролын өмнө зогсож байсан юм. Тухайн үед ч “Яаж шавар намгаас гарахаа өөрсдөө мэдэг” гэдэг хүмүүс байж л байсан. Харин миний хувьд ухаантайд тооцогдох хүмүүс “Энэ асуудал бол

бидний хамтын асуудал байх ёстой. Дайнд ялж болсон юм, энхийн цагт ч ялж болно” гэж хэлж байсан юм. Тухайн үед ухаантайчууд нь дийлсэн учраас тэдний амжилтын түүх эхэлсэн юм. Энэ амжилтын түүх өдгөө ч үргэлжилсээр байна. Эдгээр улсуудыг Виржин, Нью Жерси, Вермонт, Хойд Каролин гэдэг, тэд хамтдаа арван гурвуулаа байсан юм. Зовлон зүдгүүр тохиолдсон үед хамтдаа байж чадсан учраас тэд АНУ-ын суурийг зангидаж чадсан юм. Энэ түүх бидэнд хямралаас гарах хоёр зам байдаг гэдгийг харуулж байна. Тэгэхлээр бид энэ хоёр замын бурууг нь сонгож болохгүй биз дээ?, журмын нөхөд минь.

Түүх бидэнд ямар сургамжыг өгөв өө? Бид “ Шотландууд цаашаа, түрийвчээ хаалаа. Асуудлаа яаж шийдэхээ өөрсдөө мэдэцгээ” гэж хэлж болно. Эсхүл бид өөрсдийн замаар замнаж “Хямрал шинэ эхлэлийн сигнал байх ёстой” гэж хэлээд урагшилж болно. Та нарыг надад итгэхгүй байгааг би мэдэж байна, гэхдээ надад бахархахыг минь зөвшөөрөөч. Дайны хүнд бэрх үеийн дараагаар бидний аав, ээжүүдийн байгуулсан холбоог бид эдийн засгийн зовлон бэрхшээл тохиолдоод байгаа энэ цаг үед улам бэхжүүлж шинэчлэх ёстой. Чухам энэ бол ирэх жилүүдэд бидний хийх ёстой ажил. Хуучин Европ хангалтгүй гэдэгт эргэлзэх хэрэггүй болсон. Европыг шинэчлэхийн тулд илүү хүчтэй холбоо хэрэгтэй, энэ хямралыг хэрхэн даван туулах талаар заавал биелүүлэх, итгэж болох амлалтуудыг бид бие биедээ өгөх ёстой. Ингэж байж шинэ итгэлцэл бий болно. “Энэхүү “Европыг шинэчлэх холбоо” шинэ сэргэлтийн сигнал болж оройтлоо гэхэд өнөөдрөөс хэтрэлгүйгээр бүгд нөхцөл байдлын чухлыг ойлгогчид Хэн нь ч байсан ганцаараа чадахгүй гэдгийг

ойлгох болно. Бид бүгдээрээ өөрийнхөө сүүдэр дээгүүр харайх хэрэгтэй болно.

Зарим зүйлийг бид нэн даруй хийх хэрэгтэй. Үүнийг Хэлмут Шмидт өнөөдөр сонссон бүхэнд ойлгомжтойгоор хэллээ. Тэгэхгүй бол өнөөдөр тавьсан суурин дээр шинэ байшин баригдах хүртэл олон жил өнгөрнө. Хамгийн чухал нь” Бид хүсэл эрмэлзэлтэй, барилгын зураг, төлөвлөгөөтэй байх ёстой. Одоо бидэнд хэрэгтэй байгаа европын шинэ холбоог байгуулахын тулд бид дараах зоримог долоон алхмыг хийх хэрэгтэй.

Бидэнд европын эв санааны нэгдлийн талаар тодорхой ойлголт хэрэгтэй. Гэхдээ нэг зарчим тодорхой байх ёстой: Бусдын тусыг авсан нь өөрөө ч бас хүчин зүтгэл гаргах хэрэгтэй. Гэхдээ ” Европын ард түмнийг зах зээлүүд хооронд нь эвдрэлцүүлэх ёсгүй. Нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгнийхээ төлөө байх ёстой.” гэдэг зарчим энд шийдвэрлэх үүрэгтэй.

Харин бид нэг гарчиг тавиад орхичихож болохгүй. Ийм учраас би зарим зүйлийг тодруулахгүй бол болохгүй нь, тэвчээртэй сонсохыг хүсье. Миний хэлэх зүйл бол та бүхний ширээн дээр бэлэн байж байх ёстой байсан идэвх санаачилгын өргөдлийн үндэслэл болох ёстой.

Эдгээр алхмуудын дундаас хамгийн түрүүнд хийгдэж ёстой алхам бол төрийн болон засгийн газруудын тэргүүнүүд дамын наймаа, ашиг хонжоо олох оролдлогын эсрэг бүх хүчээрээ тэмцэж урьдчилсан байдлаар дэлгэгдээд буй авралын шүхрийг аль болох үр дүнтэй ашиглаж зөвхөн онц

шаардлагатай тохиолдолд хэмжээг нь нэмэгдүүлж байнгын ажиллагаатай европын тогтворжуулалтын механизмыг аль болох хурдан хугацаанд бий болгох талаар тохиролцоонд хүрэх хэрэгтэй байна. Энэхүү байнгын ажиллагаатай тогтворжуулалтын механизм Европын Валютыг фондын цөм нь болох ёстой юм. Энэ л бидэнд хэрэгтэй байна.

Хоёрдугаарт бидэнд өргөн хүрээтэй европын бүтээн байгуулалтын хөтөлбөр хэрэгтэй байна. Үүнийг хийх хэрэгтэй гэдгийг Хэлмут Шмидт өнөөдөр хэлсэн. Учир нь бид цаг алдахгүйгээр өнөөдөр нүүрлээд буй эдийн засгийн бууралтын эсрэг тэмцлээ эхлүүлэх ёстой. Хэрэв Европ өнөөдрөөс идэвхтэй үйл ажиллагаа эхлүүлэхгүй юм бол дэлхийн эдийн засаг бүхэлдээ бууралтын эргүүлэгт татагдан орох болно. Энэ нь: бодит эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтад тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой гэсэн үг. Бидэнд европын аж үйлдвэрийн шинэ бодлого хэрэгтэй. Өнгөрсөн жилүүдэд хэрэгжүүлсэн цэвэр санхүүгийн эдийн засгийн бодлого, бодит эдийн засгаас санхүүгийн зах зээлийг салгах зам бол алдаа байсан гэдгийг бид тодорхой хэлэх учиртай. Европ өөрийн хүчтэй талууд дээрээ тулгуурлах ёстой. Нөөцийг ариг гамтай хэрэглэдэг, инновацийг дэмжсэн өндөр үнэлэмжтэй ажлын байрыг бий болгодог тогтвортой өсөлтийн загвар манай бүс нутагт хэрэгтэй байгаа юм.

Гуравдугаарт бид залуучуудын ажилгүйдлийг бууруулахад хүчээ нэгтгэж ихээхэн хүчин чармайлт хэрэгтэй байгаа юм. Испанид 40 хувь, Өмнөд Италид залуучуудын тэн хагас нь ажилгүй байгаагаас илүү ичгүүртэй зүйл Европт алга. Ажилгүйдэл нийгмийг урж тасдан өөрийн хүчээр амьдрах

гэсэн хичээл зүтгэл бүрийг үгүй хийсээр байна.

Хэрэв бид энэ хоёр асуудлыг хоёуланг нь шийдвэрлэхийг зорьж байгаа бол энэ бүхэн “үнэгүй” олдохгүй, бидэнд эдгээрийг шийдвэрлэх санхүүгийн нөөц хэрэгтэй. Энэ эх үүсвэрийг хаанаас бүрдүүлэх бэ? Тэгэхлээр бүрх малгайгаа тосоод нийслэл хотын дундуур явж мөнгө гуйх уу? Гуйлаа гээд бидэнд мөнгө өгөх хүн олдохгүй гэдгийг би та нарт хэлчихье. Үүний тулд бид эцсийн эцэст санхүүгийн зах зээлүүдэд татвар ногдуулах ёстой.

Үүнийг тойроод гарчих өөр зам байхгүй. Үнэн хэрэг дээрээ бид нэлээд зүйлийг хийчихсэн. Бид Шойвлер, Меркел, Европын комиссыг үгүй гэж хэлэх аргагүй байдалд оруулж чадсан. Энэ хооронд би ядахдаа “Санхүүгийн зах зээлийн мөнгө гуйвуулгын татвар-Finanzmarkttransaktionssteuer” гэдэг үгийг зөв хэлж чаддаг болсон. Гэхдээ хэлж сурна гэдэг хангалтгүй. Хэлээд зогсохгүй хийж эхлэхийг бид хүлээж байна. Гэхдээ тун удахгүй.

Дөрөвдөх тулгуур: Бид санхүүгийн бодлогод хуульчлан баримтлах журмуудыг тогтоож өгөх ёстой. Энэ бол хуучин Валютын сангийн барилгын зохион бүтээлтийн алдааг засаж залруулахад шаардагдах алхам. Эдгээр нь: Заавал дагаж мөрдөх ёстой өр тавьж болох дээд хязгаар, ногдуулах торгуул шийтгэлийг тогтоож өгнө гэсэн үг. Эдгээрийг гэрээгээр баталгаажуулах ёстой, Тэгэхдээ парламентын хяналтаас хэзээ ч гадуур байх ёсгүй. Дээрээс нь нэмж хэлэхэд шаардлагатай газарт нь дархан эрхийг олгох хэрэгтэй.

Гэхдээ энэ бүхэн хангалтгүй. Европын нэгдсэн зээллэг удахгүй

бий болно гэдэгт би эргэлзэхгүй байна. Харин эдгээр нь хэрэгсэл болохоос биш шийдэл биш. Жинхэнэ Санхүү-Валют-эдийн засгийн холбоо бидэнд хэрэгтэй байгаа бөгөөд уг холбоод нэгдсэн зээллэгээс илүү ихийг хийх шаардлагатай. Татварыг нуун дарагдуулахтай тэмцэх, компаниудын татвар зэрэгт хэмжилтийн нэгдсэн баазыг бүрдүүлэх, мөн түүнчлэн санхүүгийн зах зээлийн зохицуулалт зэрэг өргөн хүрээг хамарсан энэ нэрэндээ эзэн болсон жинхэнэ холбоо хэрэгтэй байна.

Надад ажиглагдсан нэг зүйл бол бид бүгдээрээ энэ хооронд манай намынхан ч зөвхөн европын өрийн хямрал гэж ярьцгаадаг болж. Харин энэ хямрал санхүүгийн зах зээлийн хямралаас эхтэй гэдгийг хэн ч ярихаа больсон байна. Хар-Шарын эвсэл энэ талаар сонсохыг ч хүсэхгүй байна. Би Пеер Штайнбрүкээс шинэ он гарах хүртэл санхүүгийн зах зээлийг буцаагаад хэвэнд нь оруулахад шаардагдах арга хэмжээнүүдийн каталогийг бүлгийнхээ гишүүдтэй нийлээд боловсруулаад өгөөч гэж хүссэн байгаа. Хэрэв бид л энэ ажлыг хийхгүй юм бол өөр хэн ч хийхгүй. Тийм болохоор энэ бидний үүрэг.

Ингээд би асуудлын амин сүнс болсон сэдэв рүү орёё. Миний бодлоор энэ бол хамгийн чухал асуудал, үүнийг шийдэхгүйгээр бүх зүйл гацаанаас гарахгүй. Би усанд живчихгүйхэн шиг толгойгоо усны түвшингээс дээш цухуйлгаж байхад шаардагдах нөхцөлүүдийг түрүүн нэрлэсэн. Гэхдээ би та нарт “Хуучин өрийн асуудлыг оновчтой, оюунлаг аргаар шийдвэрлэхгүйгээр бидэнд эхнээсээ эхлээд ямар ч боломж байхгүй” гэдгийг хэлье. Одоо байгаа чигээр нь орхичих юм

бол улс орнууд яах ч аргагүй байдалд орсны улмаас өөрөө өөрийгөө дүүжлэх болно. Грек орны уналтын жишээг би та бүхэнд сануулга болгох үүднээс дурдаад өнгөрье. Өр хааш нь хөтөлдөг бэ? гэдгийг та бүхэн бэлхнээ харж байна. Тэд төсвийн сахилгын дүрэм тогтоож энэ дүрмийнхээ дагуу тогтмол хэмнэлт хийж байна. Гэсэн хэдий ч өр нь байнга нэмэгдсээр байна. Харин бид өрийг боомилж чадах юм бол ямар үр дүн гарах нь ойлгомжтой. Зөвхөн өр буурсан нөхцөлд л бид амжилтанд хүрч чадна. Харин өрийг яаж бууруулах бэ? Магадгүй өрийг хязгаарлаж болох юм. Энэ хооронд бид өөрийн гэсэн туршлага хуримтлууллаа. Энэ аргыг олон удаа давтан хэрэглэх боломжгүй. Ямар үр дүн гардгийг ч бид мэднэ.

Би намынхаа өргөдөл болон энэ илтгэлээ бэлтгэж байх явцдаа: Бид өөрсдийнхөө хуримтлуулсан туршлагаас яагаад хямралыг гэтлэхэд ашиглаж болохгүй гэж? гэдэг асуулыг өөртөө тавьсан. Магадгүй одоо үүсээд байгаа нөхцөл байдал бүх талаараа төстэй биш байж болох ч хоёр Герман улс нэгдсэний дараах үетэй тун төстэй байдал үүсчихээд байна. Тухайн үед бид өвийн дарамтаас гарах санг бүрдүүлж энэ сангийнхаа тусламжтайгаар өнгөрсөн үеэс өвлөгдөн ирсэн зарим нэг санхүүгийн ачааллаас гарч байсан. Энэ бол асуудлын зангилаа. Би Европын хуучин өрийн эдийн засгийн арга хэлбэр зарчмын хувьд төстэй гэдгийг олж харлаа. Би өөрийгөө тун мэргэн санал дэвшүүлж байна гэж бодож байна. Одоо байгуулах сангаа Европын өр барагдуулах сан гэж нэрлэе.

Би "Европын өр барагдуулах сан гэдэг энэ хэрэгслийг

бий болгох зориг хүч дутвал бүх зүйл хэвэндээ орохгүй, гацаа арилахгүй” гэдэгт маш итгэлтэй байна. Зөвхөн энэ хэрэгсэл Европын Валютын санд үүсээд байгаа одоогийн нам жим байдал, эсхүл хоцрогдлыг арилгаж чадна. Эдийн засгийн арга хэлбэрийн тухай миний энэ санал бол өрөө барагдуулахын тулд өрнөөсөө их өрийн баталгаа гаргадаг одоогийн практикаас ухамсартайгаар ухрах боломж юм. Энэ бол өрийн хэмжээ нь ДНБ-нийхээ 60 хувиас дээш гарсан европын орнууд өр барагдуулах хамтын хариуцлагын санд өрөө шилжүүлэх тухай санаа юм. Дараа нь улс орон бүрт төлөвшилтийн замыг тогтоож өгнө. Дараагаар нь орон бүрт 20-25 жилийн хугацаанд өрийг буцаан төлөх зарчмыг тогтоож өгнө. Энэ арга яагаад мэргэн санаа юм бэ? гэвэл энэ нь өөрөө социалдемократ загвар юм. Өр барагдуулалтын шатанд хамтын хариуцлага хүлээх учраас их өртэй орнуудад хүүгийн давуу тал бий болж хүүгийнхээ зарим хэсгээр хуучин өрөө барагдуулах боломжтой болно. Ийм учраас энэ бол мэргэн санаа. Иймээс би та бүхнийг энэ саналыг дэмжээсэй гэж хүсэж байна. Журмын нөхөд минь. Энэ бол асуудлын амин сүнс юм шүү.

Ингээд би зургаагийн тоон дээр ирлээ. Бидэнд нэгдсэн татвар, төсвийн санхүүгийн бодлогын ирээдүйн зохицуулалтын цөмийг бүрдүүлэх, түүчээ тогорууны үүрэг гүйцэтгэх бүлэг хэрэгтэй байна. Энэ цөмд багтан орох боломж бүгдэд нээлттэй, хэнийг ч тойргийн гадна орхихгүй. Гэхдээ бидэнд Европт төвийн татах хүчний үүргийг гүйцэтгэх байгууллага хэрэгтэй байна. Энэ талаар бүх хүн сонсох дургүй байгаа гэдгийг ч би мэдэж байна. Гэхдээ миний бүрэн итгэлтэй хэлж чадах зүйл бол “Хамгийн удааныхаа хурдаар урагшлах юм бол

Европ бүтэлгүйтэх болно". Ингэж таарахгүй. Бид бүгдээрээ хамтдаа урагшлах ёстой. Үүний тулд бидэнд хүндийн хүчний төв хэрэгтэй. Мэдээж энд Польш зэрэг бүх орон багтана. Тэр ч байтугай би нэгэн цагт Ваймарын гурвалжинг бүрдүүлж байсан Герман, Франц, Польш улсууд миний яриад байгаа хүндийн төвийг бүрдүүлж чадна хэмээн төсөөлж байна.

Одоо би 7-р буюу сүүлчийн алхмын талаар ярья. Энэ алхам нь чадалтай нь чадалгүйнхээ өмнө хариуцлага хүлээдэг зарчмыг Европт бэхжүүлэхэд хэрэгтэй. Яагаад би энэ алхмын талаар ярих болов? Учир нь би үүнийг өөрийн биеэр мэдэрч байгаа учраас хэлж байгаа юм. Та нар ч гэсэн намын үүр, хороод, гудамжинд олон хүмүүсийг, заримдаа манай намын нөхдийг ч юу Европын эсрэг болгоод байгааг мэдэрч байгаа. Энэ бол нэг талаас татвараас зугтаагсдад ямар ч шийтгэл ногдуулахгүй байгаа явдал, нөгөө талаас санхүүгийн зах зээлийн зохицуулалтанд ямар ч ахиц дэвшил гарахгүй байгаа мөртлөө жижиг сажиг зүйлсийг зохицуулалтанд оруулахын төлөө үхэлдэж ямар учраас тэгээд байгаа нь мэдэгдэхгүй дарамтыг бий болгоод байгаа нь хүмүүсийг европын эсрэг болгож байна. Би энд өргөст хэмх хэдэн градусуар мурийсан бэ? гэдгийг тогтоох гээгүй, Европын Холбоо саяхнаас санаа тавьж эхлэхээр шийдээд байгаа дунд сургуулийн сурагчдын өглөөний цайны талаар ярих гээгүй, харин хуримтлалын касс, нийтийн тээвэр зэрэг орон нутгийн оршихуйн амин чухал асуудлыг ярьж байна. Тухайн орон нутагт юунаас болоод болохгүй байгаа нь тодорхой зүйлүүдийг бид өөрсдөө шийдчихнэ. Эндээс улс төрийн үйл ажиллагааны чадамжийг эргүүлэн олох ажил ч мөн эхэлнэ.

Би үгийнхээ төгсгөлд ирлээ. Бид улс төр бол зах зээлээс

хөөгдөж туугдагсад гэж ярихыг олонтаа сонсох боллоо. Энэ өгүүлбэрийг бичиж байх явцдаа энэ хооронд улам ч илүү түгшүүртэй болчихоо юу? гэж надад бодогдсон. Үнэн хэрэг дээрээ зах зээлүүд улс төрийг өмнөө оруулаад түрээд байхаа ч больчхож. Тэд улс төрийг үл тоож байна. Улс төр тэдэнд хэтэрхий сэтгэлийн хөөрлөөр шийдвэр гаргадаг, хэтэрхий удаан, хэтэрхий заваан, хэтэрхий хүндрэлтэй санагддаг болсон байна. Ардчилал бага байх тусмаа зах зээлд сайн. Энэ өгүүлбэр богино хугацаанд өндөр ашиг олох зорилго бүхий сангуудын удирдах зөвлөлийн хуралдаан дээр төдийгүй хаа сайгүй сонсогддог болж. Сүүлийн үед Хятадад шийдвэр гаргалтын зам, хэрэгжүүлэлтийн хугацаа богиноссон талаар сурталчлах болж. Иймэрхүү яриа хэлц өнөөдөр улс төрд улам бүр моданд орж байна. Саяхан “Дэлхий” сэтгүүлд “Ардчилал их мөнгөтэй харьцаж чадах уу?” гэдэг гарчигтай нийтлэл хэвлэгдсэн байлаа.

Гэхдээ би та бүхэнд: Би хэнээ өвчин тусаагүй гэдгээ хэлье. Парламентын эсрэг үзэл, ардчиллыг үл тоох байдал Германд төдийгүй дэлхий дахинд ямар их хор хохирол дагуулсныг өнгөрсөн үеийн түүх гэрчилнэ. Ийм ч учраас бид эхлэл тавигдахаас сэргийлж мэдрэмжтэй байх ёстой.

Меркел, Саркози Папандреоу хоёр дунд сургуулийн сурагч хөвгүүд шиг Коте де Азурын усанд сэлэлтийн газраас ишлэл татаж бэлэн болгоод зориг нь мохож байдаг, өөрөө зориглоогүй учраас ард түмнээсээ асууж байдаг Европ гэж байх уу? Үүнийг би үргэлж санаж байх учиртай. Эрхэм нөхөд өө, Жорж Папандреоу сүүлийн хэдэн сард бусад засгийн газруудын тэргүүн нар засаг тэргүүлэх нийт хугацаандаа

гаргасан зоригоос илүү зоригийг гаргаж өөрийнхөө кариерийг золиосоллоо.

Франкфуртын аль нэг банкны цамхгийн сүүдэрт бий болсон, Франкфуртын дугуйлан хэмээх аливаа хараа хяналтаас ангид удирдах дээд байгууллага европын үлдсэн бүх хэсэгт чухал шийдвэрээ цээж бичлэг хийлгэж байгаа юм шиг тулгаж байдаг европ гэж байх уу? Франц улсын ерөнхийлөгч уг дугуйланд хамрагдаж болох юм. Илбэ шидийн ширээний хөзрийн ноёны үүрэг гүйцэтгэгч маягаар. Тэгэхгүй юм бол канцлер, капитал хоёр хоёулхнаа үлдэж орхино.

“Европ яагаад Технократынуудын толгойлсон засгийн газрыг засаглах урлагийн мастер болгон өргөмжлөхдөө хүрчхээ бэ? хэмээн асууж байна. Италийн аж үйлдвэрийн холбоо эх оронд нь засгийн газар солигдсоныг ачаанаас салсан мэт сэтгэл амран хүлээн авч байгаа нь ямар учиртай юм бэ? Яагаад? Учир нь сонгууль явуулалгүй засгийн газар солигдчихсон болохоор тэгж байгаа юм. Берлускони өнгөрсөн түүх болсонд италичуудын нэгэн адил миний ч сэтгэл амарсан гэдгийг хэлье.

Гэхдээ эцэст нь Европт хаа сайгүй нөхцөл байдал хүндэрч байгаа энэ үед банкир байхдаа энэ бүх бүтэлгүйтлийн эхийг хамтран тавилцсан Голдман Сакс банкны хуучин банкирыг бүх засгийн газрууд хүлээн аваад байж таарахгүй. Ийм юм байж таарахгүй.

Ийм учраас эрхэм журмын нөхөд минь. Хэрэв бид Европын Холбоог бэхжүүлэхийг хүсэж байгаа юм бол “Европт илүү

ардчилал хэрэгтэй” гэдгийг хэлэх ёстой. Бидний Европ нууц хэлэлцээ, мухардлаас гарахын тулд аргагүйн эрхэнд хэрэгжүүлдэг дүрэм журамд хүлэгдсэн Европ байж таарахгүй. Бид 19-р зуунд эргэж очихыг хүсэхгүй байна. Би тэндээс ирсэн. Харин бид 21-р зууны европыг бүтээн байгуулахыг хүсэж байна.

Эрхэм журмын нөхөд минь, Бид энэ тухай ойлголтоо нэг мөр болгож цэгцлэх хэрэгтэй байна. Энэ долоо хоногт Европ ямар замаар замнахыг бид шийдэх ёстой. Жижиг, том улсуудын эрин үе рүү буцах уу? эсхүл жинхэнэ утгаараа хамтын ажиллагаа, эв санааны нэгдэлтэй энх тайван дэглэм рүү урагшлах уу? Сайн Европын чиглэлд урагшлах уу? эсхүл Европын төгсгөл рүү ойртох уу? гэдэг хоёр сонголтын аль нэгийг сонгох ёстой.

Энэ хэдэн өдрүүдэд бид зөвхөн сөрөг хүчний хувьд яах бэ? гэдгийг ярих нь хангалтгүй юм. Энэ бол Меркель болон Хар-Шарын эвслээс илүү чухал асуудал. Энэ бол эрх мэдлийн тактикийн заль мэххэн, арга саамаас илүү чухал асуудал. Энэ бол илүү ч үгүй, дутуу ч үгүй улс төр бол зохицуулалт, дүрэм журмыг тогтоодог талбар гэдэг утгаар нь дахин байр сууринд нь эргүүлэн тавих тухай асуудал яригдаж байна. Үүнийг бид эргүүлэн олж авчрах ёстой. Энэ бол бидэнд ногдож буй чухал үүрэг.

Энэ бол бидэнд ногдож буй том үүрэг. Энэ бол бусдад найдаад орхиж болохгүй чухал үүрэг учраас бид л хийх ёстой ажил. Хэдийгээр цаг үе нь бэрх ч гэлээ бид энэ үүргээс айхгүй. ГСДН 150 жилийн туршид хэцүү цагт хүнд үүргийг биелүүлсээр ирсэн юм. Бид энэ хариуцлагыг бусад нь бидний

тарьсан тариаг хурааж аваад хоосон талбай орхиод буугаад явах бүрт үүрсээр ирсэн. Би та бүхэнд “ Энэ улсыг хэдхэн жилийн өмнө шинэ эхлэлийн зам дээр гаргахын тулд гэрийн даалгаврыг хийсэн засгийн газар бол социалдемократ засгийн газар байсан. Бидний тухайн үед хийсэн зүйлийг одоо бусад европчууд хийцгээж байна. Бид үрийг нь суулгаж тариалж өгсөн, жимсийг өдгөө бусад нь хурааж байна. Хэрэв бид үүнийг хийгээгүй байсан бол манай улсад өнөөдөр байдал бусад орнуудаас илүү дээр байхгүй байсан, өнөө засгийн эрхийг барьж буй улс төрийн намууд, Христосын Ардчилсан Холбоо Нам, Христосын Нийгмийн Ардчилсан Холбоо Нам, Чөлөөт Ардчилсан Намын эвсэл ч үүнээс дор нөхцөлд ажиллаж байх байсан. Тэд үүнийг эхлүүлээгүй юм.” гэдгийг сануулъя.

Би өөрийнхөө нам ГСДН-аар бахархдаг. 2009 оноос хойш хоёр жилийн дараагаар хаа байсан тэр газартаа эргэн ирж чадсанаараа бахархаж байна. Өөртөө итгэлтэй урагшаа харан зогсож байна. Бид сөрөг хүчин учраас сөрөн зогсоогүй. Бид буруу бүхнийг бусад руу түлэхийг хүсээгүй. Бид шийдвэр гаргалтын чухал цаг үед амьдарч байгаа учраас хариуцлага хүлээхэд өөрсдийгөө бэлтгэж байна. Бид сөрөг хүчний байр суурин дээрээс биш, засгийн газрын байр суурин дээрээс энэ цаг үеийг өөрийн хүссэнээр эзэгнэхийг хүсэж байна. Үүний тулд социалдемократ канцлерын ордонд очих ёстой. Үүний төлөө бид дараагийн хоёр жилд хамтдаа ажиллах ёстой.

Баярлалаа.